

Хенри Райдер Хаггард

СОЛОМОН ХААНЫ ЭРДЭНЭСИЙН САН



Соломон хааны эрдэнэсийн сан

Зохиолч: Х.Р.Хаггард

Орчуулсан: У.Нямсүрэн

Эрхлэн гаргасан: Хөх дэвтэр хэвлэлийн газар

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Соломон хааны эрдэнэсийн сангийн эрэлд

Хүн туулахын аргагүй цөлийн тэртээ байдаг эрдэнэсийн агуйд очихоор явсан дүүгээ эрж, Английн нэгэн баян эр хэсэг нөхдийн хамт явдаг билээ. Тэр эрдэнэсийн агуйд очих хүртлээ маш олон адал явдалтай учирна. Хүүхэд насанд ер бусын сонин сайхан адал явдал сонирхдоггүй хүн гэж ер үгүй биз. “Соломон хааны эрдэнэсийн сан”-г хадгалсан асар баялаг агуйг чи нөхдийн хамт оллоо гээд төсөөлөөд үз дээ.

Нэгэн зуу гаруй жил дэлхийн хүүхэд багачуудын хамгийн амтархан уншдаг энэхүү адал явдалт зохиолыг бичсэн Р. Хаггард нь 1856 онд Английн Норфолк гүнлэгт төрсөн. Хуульч, зохиолч, агрономич мэргэжилтэй тэрээр Льюис Кэрролл, Эдгар По нартай эн зэрэгцүүц дэлхийн адал явдалт уран зохиолын гол төлөөлөгч, фантаз буюу уран сэтгэмжит чиглэлийг үндэслэгч болж чадсан юм. Хуулийн сургууль төгсөөд Өмнөд Африкт хэдэн жил болсон нь хожим түүний зохиолын баатрууд болсон хүмүүсийн ихэнхтэй учруулжээ.

Англид эргэж ирээд зохиол бичихийн зэрэгцээ хөдөө аж ахуйн чиглэлээр ажиллаж байлаа. Мэргэжлийн шалгалт өгч өмгөөлөгч болсон хэдий ч тэрээр зохиол бичихийг илүүд үзэж байв.

Хаггард сэтгэлзүй, түүхэн, уран сэтгэмжит уран зохиолын төрлүүдээр бичиж багагүй амжилтанд хүрсэн юм. Өмнөд Африкийн адал явдлын тухай өгүүлсэн “Соломон хааны эрдэнэсийн сан” зохиол нь түүнд бүх дэлхийн алдар хүнд авчирчээ.

Хаггардын олон зохиолд дамнан гардаг гол баатар нь адал явдалд дурлагч, цагаан арьст анчин Алан Квотермейн билээ.

Нэгдүгээр бүлэг

Невилл хэмээх эр

Би нэг ер бусын хачин түүх ярих гэж байна. Та энэ түүхийг дуустал уншихаараа бараг цус царцам хачирхалтай, аймаар, итгэхийн аргагүй мөртөө үнэн түүх гэдгийг хүлээн зөвшөөрөх болно. Ямар ч гэсэн энэ түүх миний цусыг нэг бус удаа мөс болгох дөхөж байсан юмдаг.

Би мэргэжлийн зохиолч биш, зүгээр л Аллан Куатермэйн гэдэг анчин хүн. Би Өмнөд Африкийн Дурбан хотод оршин суудаг цагаан арьстан, одоо тавин нас хүрч байна. Амьдралынхаа гуч гаруй жилийг Африкт ан хийж, байлдаж, алт олборлож, худалдаа хийж өнгөрүүлсэн. Би наанадаж жаран таван арслан агнасан. Жаран зургаа дахь нь над руу дайрсан бөгөөд зүүн хөлд минь түүний үлдээсэн соёоны сорви одоо бий.

Арван найман сар орчмын өмнө би ахмад Гүүд болон ноён Хенри Куртистэй анх уулзаж билээ. Тэндээс л энэ түүх эхэлсэн дээ. Тэр жил /1885/ би Бамангватод заан агнаад завгүй байлаа. Азгүйтэж, буруу шийдвэр гаргаж, өвчилсний улмаас тэр аялал олз омог муутай болсон юм.

Биеэ тэнхрүүлж аваад Кейп рүү явлаа. Кейптаунд долоо хоноод “Данкелд” хөлөг онгоцоор Дурбан руугаа буцъя гэж бодож байв. Тэр хөлөг Англиас ирэх “Эдинбургийн шилтгээн” онгоцыг хүлээж байсан юм. Би “Данкелд” дээр төрсөн өдрөө тэмдэглэх төлөвлөгөөтэй очтол нөгөө онгоц ирж, зорчигчид нь “Данкелд”- д шилжин суумагц бид хөдөллөө.

Хөлөгт шилжиж суусан зорчигчдын дотроос хоёр хүн миний анхаарлыг татсан юм. Нэг нь гуч гаруй насны, миний энэ насандаа үзсэн хамгийн биерхүү, чийрэг бадриун хархүү байлаа. Тэр бол шар үс сахалтай, хөнхөр том бор нүдтэй овойж товойсон дух, шанаатай сүрдэм царайтай нэгэн байсан бөгөөд нэрийг нь Хенри Куртис гэдгийг би зорчигчдын нэрсийн жагсаалтаас мэдэж авсан юм. Тэрбээр нэг л зүс үзсэн хүн шиг санагдаад байсан боловч хэн гэдгийг нь санахгүй байлаа.

Түүнтэй хамт бүртгүүлсэн хүний нэрийг ахмад Жон Гүүд гэж бичсэн байх бөгөөд би түүнийг харангуутаа л тэнгисийн цэргийн хүн гэж таасан. Тэр бол нар салхинд борлосон царайтай, их цэмцгэр, сахлаа нямбайлан хуссан, баруун нүднээсээ дугариг шил салгадаггүй бололтой эр байв.

Тэр орой би дарс ууж, дэмий чалчих санаатай хөлгийн лонжид ортол ноён Хенри найзтайгаа аль хэдийн ороод суучихсан байв. Бид дорхноо л заан агнах тухай яриа үүсгэгчхээд сууж байтал ойролцоох ширээнд сууж байсан, намайг таних нэг нь,

- Анчин Куатермэйн чамд зааны тухай хэнээс ч илүү яриад өгч чадна гэлээ.

Тэгтэл Куртис над руу эгцлэн ширтээд:

- Уучлаарай ноёнтоон, таны нэрийг Аллан Куатермэйн гэдэг шүү дээ гэхэд,

- Мөн байна гэж би хариулав.

Ноён Хенри, ахмад Гүүд хоёр бие бие рүүгээ харснаа Куртис над руу эргэж:

- Бид хоёр таныг олох гэж Англиас ирлээ. Тантай би аминчлан ярилцах гэсэн юм. Та манай бүхээгт ороод ирэхгүй юу, хөндлөнгийн чихнээс гадуур ярих юм байна гэлээ.

Би ихэд гайхсан боловч тэгье гэсэн юм. Түүний бүхээг маш аятайхан тасалгаа байв. Ноён Хенри нэг хундага татчихаад яриагаа эхлэв:

- Ноён Куатермэйн, одоогоос нэг жилийн өмнө та Трансваалийн Бамангвато гэдэг газар байсан байх аа?

- Байсаан гэж би хариулахдаа “Энэ хүн яаж мэддэг байна аа” хэмээн дотроо гайхав.

- Тэнд та Невилл нэртэй хүнтэй уулзсан уу?

- Невилл гэнэ ээ? Аа тийм, миний хажууд нэг билүү, хоёр долоо хоног буудалласан юм. Хэдэн сарын өмнө нэг хуульч түүнд юу тохиолдсон тухай мэдэхгүй биз гэж надаас асууж захидал бичсэн байсан шүү.

- Би мэднэ ээ, таны хариуг надад илгээсэн, даанч ойлгомжгүй байсан. Ноён Куатермэйн, та но- ёо - н Невилл хаашаа явсныг мэдэхгүй биз?

- Нэг юм дуулах нь дуулсан... гээд би үгээ таслав.

Хэсэгхэн зуур бид чимээгүй сууж, тэр хоёр дахин бие бие рүүгээ харснаа Гүүд толгой дохиход Хенри над руу эргэж хэлэв:

- Би танд үнэнийг хэлье. Таны уулзсан тэр Невилл гэдэг хүн чинь миний дүү байгаа юм.

- Нээрэн одоо харахад үнэхээр адилхан юм гээч! гэж хэлэнгээ би гуяа алгадав.

- Тийм шүү, таван жилийн өмнө, аавыг маань нас барахаас өмнөхөн миний дүү Жорж бид хоёр шүүгчид зарга мэдүүлсэн юм. Аав маань өв хөрөнгийн гэрээслэлээ дэндүү оройтсон хойно хэлсэн бөгөөд би өв хөрөнгийг нь залгамжилсан. Дүү маань үүнд их эмзэглэсэн. Би шүүгчид зарга мэдүүлж хөрөнгөө дүүтэйгээ хуваалцах гэж бодож байтал дүү маань Невилл гэсэн овогтой болоод Африк руу яваад өгсөн байлаа. Бодвол өөрийн хөрөнгөтэй болох гээ биз. Түүнээс хойш гурван жил болоход би түүний тухай юу ч сонссонгүй. Тэгээд л би санаа зовж, дүүгээ олох санаатай наашаа гарсан юм.

- Та ноён Невиллийн талаар юу мэдэж байгаагаа бид хоёрт ярина биз дээ гэж ахмад хэлэв.

Ноён Хенри урагш бөхийж миний нүд рүү эгцлэн ширтэнэ.

- Та Бамангватод байхдаа миний дүүгийн аяллын тухай юу сонссон бэ?

- Тэрнийг Соломоны эрдэнэсийн сан руу явлаа гэж сонссон.

Би тэр хоёрыг ээлжлэн харахад хоёулаа миний ам руу ширтэж байв.

- Соломоны эрдэнэсийн сан гэнэ ээ? Тэр чинь хаана байдаг юм бэ? гэж тэд нэгэн зэрэг асуулаа.

- Эрдэнэсийн сангууд хаана байдгийг би сайн мэдэхгүй... Миний нэг удаа харсан Сулиманы нуруу буюу Соломоны уулсын цаана байдаг гэсэн. Гэхдээ эндээс тэр хүртэл зуун гучин бээр зайтай. Сулиманы уулсын хойт талд Соломон хаан очир эрдэнийн сантай байсан гэх домог Африк даяар байдаг юм.

Куртис хөмсгөө буулгаж над руу духайн харав.

- Ноёнтон минь, Соломон хаан гэж библид л гардаг шүү дээ. Тэгэхлээр үнэн байх боломжгүй.

- Яагаад боломжгүй гэж? Би Африкт удаан байсан хүн шүү эрхэм ээ, би хуучны домог ч сонсож байсан, бас хуучны юм ч үзэж л байлаа. Гэвч одоо миний танд ярих зүйлээс өөр сонин юм гэж байхгүй.

Нөгөө хоёр миний ярихыг хүлээж над руу ширтэж байх зуурт би яаж эхлэхээ мэдэхгүй шалан дээр нэг дэвсэв. Дэвсэнгүүт дурсамжууд урсан ирж, би тэр жил миний майхны гадаах галын дэргэд үхэж байсан тэр хүний царай, сүүлчийн амьсгалаа татаж байсныг нь саналаа...

Хоёрдугаар бүлэг

Домогт Соломоны

эрдэнэсийн сан

- Би домогт Соломоны эрдэнэсийн сангийн тухай анх сонссоноос хойш арав орчим жил болж байна. Цөлийн зах дахь зэлүүд цэг болсон Ситандас Краал /краал - Африкийн зулу омгийн хэлээр отог гэсэн утгатай үг/ нэртэй газарт нэг өндөр туранхай португал хүн ирэв. Тэнд би нэлээд удаж байсан бөгөөд ирсэн хүн өөрийгөө Хосе Силвестре гэж танилцуулсан юм.

Маргааш нь бид хоёр бие биедээ сайны ерөөл хэлээд салахад тэр “Баяртай ноёнтоон, дараачийн удаа бид уулзахад би дэлхийн хамгийн баян хүн болсон байна гэж найдаж байна” гэсэн юм.

Би түүнд сайн яваарай гэж хэлэхдээ инээж байв. Тэр баруун зүгт элсэн цөлийн гүн рүү явсан бөгөөд тэнд очоод үзэх юмаа бодсоор байгаад галзуурсан юм байгаа биз гэж би бодож байлаа. Долоо хоног өнгөрөв. Нэг орой би “Ус! Хэн нэг нь надад ус авчирч өгөөч” гэж хашгирч байгааг сонсов.

Би Хосе Силвестрегийн дуу мөн байна гэж танилаа. Элсэн манхны хажуу дээр нэг хүн хэвтэж байгаа нь сарны гэрэлд тодхон харагдана. Тэр чадлынхаа хэрээр дөрвөн хөллөн мөлхөж байснаа босож ирээд гуйвж дайван хэд алхав. Дахин унаж, дахиад мөлхөв.

Би түүн рүү гүйж очоод өргөж босголоо. Тэр дэндүү хөнгөхөн, яс арьс хоёр л болсон байна. Нүүр нь цав цагаан болсон байх бөгөөд сарны гэрэл түүний царайг улам ч аймаар харагдуулна. Нүд нь нүүрэндээ томдсон мэт харагдаж, биед нь мах булчин гэх юм алга болсон байв. Би тэр жингүй биеийг өргөж авчраад, хөнжилд ороож галын дэргэд тавилаа. Толгойг нь өвдөг дээрээ дэрлүүлээд, лонхтой уснаас байн байн балгууллаа. Тэр гэнэт лонхтой усыг түлхээд, ам нь ангалзав:



- Уулс! Уулсыг давах хэрэгтэй, очир эрдэнэ олно, гялалзсан гоё чулуу. Гэхдээ хэрэггүй, цөл шатаана, шатаана гэж шивнэв.

- Тайван бай Силвестре, чи одоо айх аюулгүй болсон гэж би хэлэв.

Тэр чимээгүй болж лонхтой уснаас дахиад уулаа. Би түүнд усанд норгосон хачиртай талх өгөөд унтуулав. Ороо дэргэд нь ойрхон авчирч тавиад унтсан боловч Сильвестре байн байн сэрж, бувтнахад нь би босч, ус уулгаж байлаа.

Үүрээр намайг сэрэхэд тэр өндийгөөд суучихсан, цөл дээгүүр хачин гөлийсөн харцаар ширтэж байгаа нь үүрийн гэгээнд бүдэгхэн харагдав. Өглөөн нарны анхны туяа бид хоёрын байгаа өргөн талыг гийгүүлээд, зуун бээрийн цаана байгаа Сулиманы нурууны хамгийн өндөр оргилд туслаа.

- Нөгөө уул чинь тэр! Гэхдээ би хэзээ ч дахин тэнд хүрэхгүй, ер нь хэн ч тэнд хүрч чадахгүй гэж тэр хэлэв.

Тэгснээ бодлоо өөрчлөв бололтой хэсэг чимээгүй байснаа:

- Найз минь, чи энд байна уу, миний нүд харанхуйлж байна.

- Байна аа, хэвтээд сайн амар.

- Би мөдхөн хангалттай их амарна. Сонс! Би үхэж байна. Чи надад сайн үйл хийлээ. Би чамд цаасаа өгье. Чи цөлийг гаталж чадвал тэнд хүрнэ. Хурдлаарай найз минь, цаас миний

цамцанд байгаа, энэ байна, май ав!

Тэгээд цамцныхаа дотор талаас зээрийн арьсанд боож, нарийхан сураар ороосон юм гаргаж ирэв. Тэгээд боолтыг тайлах гээд чадсангүй:

- Үүнийг тайл!

Би боодлыг задалтал дээр нь үл гаргагдах бичигтэй ёрог даавуунд боосон нэг цаас байлаа.

- Найз минь, би чамд гурван зуун жилийн өмнө Соломоны ууланд амь үрэгдсэн элэнц өвөг Хосе де Силвестрагийн бичиг, зураг хоёрыг чамд өгч байна. Элэнц өвөөгийн зарц нь үүнийг Делагоа дахь гэрт нь авчирч өгсөн юм. Энд бичсэн зүйл миний үхэл боллоо. Би тэр эрдэнэсийг авч чадсангүй, харин чи түүнийг олбол дэлхийн хамгийн баян хүн болно. Харин хэнд ч бүү өгөгтүн! Өөрөө л яв!

- Би явна аа, чи дахиад өөрийгөө бүү зовоо.

- Тийм ээ, би одоо амарна, амарлаа гээд толгой нь гэдийж, хөдөлгөөнгүй болов.

Зүрх нь цохилж байсан боловч тэр амьсгал хураасныг би мэдэж байлаа. Бид гүнзгий булш ухаж, түүнийг оршуулаад дээр нь том чулуун овоо босгосон болохоор цөөвөр чононууд ухаж гаргаж чадахгүй гэж бодож байна. Тэгээд бид Ситандас Краалаас хөдөлсөн юм.

Миний санаанд тэр газрын зураг байгаа ч гэсэн одоо бүдгэрчээ. Надад хэлж байсан тэр үгс, дууны өнгө ч сэтгэл хөдөлгөхөө больжээ.

- Бичиг байсан гэв үү? Ямар бичиг байсан юм бэ? Жаахан дэлгэрэнгүй ярьж өгөөч гэж ноён Хенри гуйлаа.

- Тэгье л дээ гээд би халааснаасаа тэмдэглэлийн дэвтрээ гаргав:

- Би хуулбарлаж авсан юм. Нэг португал худалдаачинд үзүүлж орчуулга хийлгэснээс өөр хэнд ч үзүүлээгүй юм. Тэр хүн тэгэхэд шал согтуу байсан тул маргааш өглөө нь юу ч санахгүй байсан. Жинхэнэ эх нь Дурбанд, гэрт маань байгаа. Газрын зургийн хуулбар нь л энд байна.

Нөгөө хоёр миний дэвтэр рүү тонгойлоо.

- Бүгд байна: цөл ч байна, Соломоны уулс ч байна, эрдэнэсийн агуйн ам ч байна, хараач гэж Гүүд дуу алдав.

- Бичиг нь юу гэж байгаа юм бэ? гэж Хенри асуулаа.

- Ингэж бичсэн байна: Би өөрөө Шебагийн хоёр хөх гэж нэрлэсэн хоёр шовгор уулын зүүн талын хөхний товчны хойт тал дахь цас ч байхгүй жижигхэн агуй дотор өлсөж үхэж байгаа Хосе де Силвестра би вээр үүнийг 1590 онд хувцасныхаа үлдэгдлээр цаас хийж, ясаар үзэг хийж, цусаараа бэх хийгээд бичиж байна. Хэрэв миний зарц амьд мэнд, намайг олбол энэ бичгийг Делагоад хүргэнэ. Миний найз /нэр нь гаргагдсангүй/ үүнийг хааны сонорт хүргэж,

хаантан арми илгээж, тэр арми цөлийг амьд гатлан уулсыг давж, эрэлхэг дайчин кукуаначууд болон тэдний ид шидийг дийлж гарвал Соломоноос хойшхи хамгийн баян хаан болно. Би Цагаан үхлийн цаадах Соломоны уурхайд хадгалаастай байгаа тоймгүй их очир эрдэнийг өөрийн нүдээр харсан. Гэвч урвагч Кагуулын гайгаар харамсалтайяа амь үрэгдэхэд хүрэв. Наашаа ирэх хүн энэ газрын зургаар явж, Шебагийн зүүн хөхний цаст оргил өөд авирч, Соломоны тавьсан их зам хойт талд нь байгаа товчинд нь хүрээд тэндээс хааны ордон хүртэл гурав хоног аялна. Кагуулыг алаарай. Миний сүнсний төлөө залбираарай. Сайн сайхныг хүсье.

Хосе де Силвестра

Бид хэсэг дуугүй суусны дараа ахмад Гүүд:

- За тийм байж. Би л лав түүхийн ном юм уу өөр ямар нэг номноос ийм юм уншсан бол дүүжилж үхэх байсан, яриад байх юм алга гэв.

- Энэ бол өөр үлгэр байна шүү ноён Куатермэйн гэж Хенри бодлогошронгуй хэлэв.

- Тийм шүү ноён Хенри, таны дүү Соломоны уулсыг давж, очир эрдэнийн санг олно гээд л цөл рүү явчихсан байна шүү дээ.

- Тийм байж. Гэхдээ юунд найдаж тийшээ явсан юм бол?



- Энэ түүхийг тэр хаанаас сонссоныг би мэдэхгүй. Тэр хэмжээлшгүй их баялагтай болно гэж хэлж байсан. Тэгэхлээр очир эрдэнийн сангийн төлөө явсан байж магадгүй. Тийм бол тэр тухай ярихгүй байсан биз дээ. Тэр цөлийг туулахаар Кафирын анчин Жим гэдэг их сайн хүнтэй хамт явсан гэсэн.

- Ноён Куатермэйн, би дүүгээ эрж олохоор явж байна. Би тэр Соломоны уулс руу явлаа, шаардлагатай бол тэр уулсыг давна. Дүүгээ амьд ба үхсэн алин болохыг мэдэх хүртлээ эрэх

болно. Та надтай хамт явах уу?

- Үгүй дээ, ноён Хенри. Уучлаарай, би иймэрхүү зэрлэг галууны зодоонорхуу юманд явахад хэтэрхий хөгшиднө.

- Хамт явъя л даа, ноёнтоон! Та бидэнд их чухал хүн байна. Та газар орныг мэднэ, хүмүүсийг нь танина гэж ахмад Гүүд сандрав.

- Би баян хүн. Та хүндэтгэх шалтгаантайгаар юу ч хүссэн би өгнө. Бүх зардлыг би даана, хэрэв эрдэнэс олбол Гүүд та хоёрт тэнцүү хувааж өгнө. Би тэр эрдэнэсийг авахгүй.

- За яахав, би явъя л даа.

- Жинхэнэ эр хүн!

- Хэрэв та миний аяллын зардалд таван зуун паунд өгвөл шүү дээ.

- Энэ асуудал шийдэгдсэн.

- Тэгвэл би танд бололцооныхоо хэрээр үйлчилнэ.

- Би танд үгээр илэрхийлшгүй их баярлаж байна. Ийм чухал үйл явдлыг тэмдэглэж наргицгаая! гэж гараа алдлан хэлээд виски хундагалахад нь би:

- Бид Ситанда Краалаас цааш явах ганц ч хүнийг нутгийн уугуул хүмүүсээс ятгаж чадна гэдэгтээ эргэлзэж байна гэв.

Хенри надад хундагатай виски өгч, өөрийнхийгөө өргөөд:

- Таны төлөө энэ хундагыг өргөө, цөлийн цаана гарахын төлөө! Бид гарз хохиролгүй гарчих ч юм билүү, хэн мэдлээ!

- Цөлийн цаана гарахын төлөө! гэж хашгираад Хенри Гүүд хоёр хундагаа хоослоход би ч дагалаа. Дараа нь тэр хоёрт сайхан амрахыг ерөөгөөд өрөө рүүгээ явж байхдаа хөөрхий Хосе де Силвестра болон очир эрдэнэсийн тухай бодож байлаа.

Гуравдугаар бүлэг

Умбора

Бид нэгдүгээр сарын эцсээр Дурбанаас гарч, олон зуун бээр зам туулан, тавдугаар сарын хоёр дахь долоо хоногт Ситандас отогт хүрэв. Зургаан хүн хөлсөлж, ачаагаа үүрүүлээд Краалд хүрэх байлаа. Тэд отгоос цааш бидэнтэй явахгүй бөгөөд ганцхан Вентвогель нэрт хар арьстан л бидэнтэй цааш явах болно.

Бид үдэш болж байхад буудаллаж байтал нэлээд хол асар том түймрийн гал дүрэлзэж байгааг үзэв. Гүүд ачаа бараагаа харж, ард үлдсэн ба Хенри бид хоёр Сулиманы нурууны барааг олж харахыг хичээн цөлийн зүг хараа бэлчээж явсан юм. Уулсын бараа алс тэртээгээс удахгүй харагдах ёстой байв.

Бид хоёр алсын түймрийг харж жаахан зогсоод отог руугаа эргэв. Тэгтэл гэнэт нэг бул чулууны араас өндөр зулу дайчин гарч ирээд жадаа өргөн ёсолж:

- Цагаан эрхмүүд ээ, та бүхнийг хүндэтгэн мэндчилж байна. Та нарыг удахгүй цөл гатална гэж би дуулсан юм. Үнэн үү? гэж асуув.

- Чи яах гэж асууж байгаа юм бэ?

- Та нартай хамт явах гэсэн юм аа, Макумазан (Макумазан гэдэг нь зулу хэлээр загасан нүдэт гэсэн утгатай бөгөөд намайг тэр тэгж нэрлэдэг болов, Куртисыг “инкубу” буюу заан гэдэг, Гүүдийг “боугван” - шилэн нүд гэдэг байж билээ).

- Танайхан чамайг хэн гэж дууддаг вэ?

- Умбора.

- Чиний отог хаана байдаг вэ?

- Надад отог байхгүй. Би олон жил ганцаараа тэнэсэн. Манай омгийнхон эндээс их хол хойт зүгт байгаа, одоо би тэдэн рүү явж байна. Би эр зоригтой, чадалтай хүн. Надад хөлс мөнгө хэрэггүй, хоол унд байхад л болно.

- Куатермэйн, тэр юу гэж хэлэв? гэж Хенри Умбораг нүдээ онийлгон харж байснаа асуулаа.

- Энэ бидэнтэй хамт явахыг хүсч байна, хөлс мөнгө авахгүй гэнэ ээ. Надад энэ нь таалагдахгүй байна. Энэ хүн ердийн зулу нараас их өөр харагдаж байна.

- Надад энэ хүн зэрлэг бух шиг сайхан бие бялдартай юм шиг санагдаж байна. Би шалгаж үзмээр байна.

- Умбора, нөмрөгөө тайлчих гэж би хэлэв.



Тэр бидний өмнө нөмрөгөө тайлж, хүзүүн дэх сахиус, нууц эрхтний хаалтаас өөр юмгүй биеэ эгцлэн зогсов. Би урьд нь ийм сүрлэг сайхан биетэй африк хүн харж байгаагүй билээ. Зургаан фут өндөр, өргөн цээж, тэгшхэн мөр, хүчирхэг хөлтэй энэ хүн зулу нараас цайвар арьстай байлаа.

Хенри түүн рүү дөхөж очоод, бардам, ихэмсэг царай руу нь ширтэн зогсов. Тэр хоёр бие бялдраар адилхан, хэн хэнээсээ дугуугүй хүчирхэг сайхан эрс байлаа.

- Тэр надад таалагдаж байна, би хамгаалагчаар авья гэж Хенри хэлэв.

- Цагаан ноён чамайг хамгаалагчаараа авья гэнэ ээ гэж би Умборад зулу хэлээр хэлэв.

- Их сайн байна, чи бид хоёр жинхэнэ эр хүн гээд Умбора Хенригийн нүд рүү эгцлэн харж, дараа нь над руу эргэж хараад, - Макумазан, чи миний хэл болж, миний эзэнд үгийг минь дамжуулж өг гэлээ.

- Умбора чамтай ярилцана, намайг орчуул гэж байна гэж би Хенрид хэлэв.

- Зүйтэй, юу хэлэхийг нь сонсьё.

- За яриарай, Умбора.

- Цөл дэндүү уудам, ус байхгүй. Уулс их өндөр, цас мөсөөр хучигдсан. Та цаад талд нь яаж гарах юм бэ? Яах гэж гарах гээд байгаа юм бэ, эзэн минь ээ?

- Цагаан ноёны цус нэгт дүү нь тийшээ түрүүлж явсан. Ах нь дүүгээ олох араас явж байгаа юм.

- Цагаан ноёнтон та, хар негр бид хоёр маш их адилхан юм байна. Тийм болохоор би ч гэсэн уулсыг давж дүүг чинь хайя даа гээд Умбора инээв.

Надад нэг л сэжиг төрж, би түүн рүү сэжиглэнгүй харав:

- Чи уулсын тухай юу мэддэг юм бэ?

- Маш бага мэднэ, тэр их хачин газар, ороолон, шулмуудын орон, бас олон сайхан юмны орон, эрэлхэг хүмүүс, цас мөсөн оргил, өргөн их замын орон юм гэнэ лээ. Би энэ тухай нэг цагаан хүнээс сонссон.

Би түүн рүү дахиад л сэжигтэйгээ харлаа. Энэ хүн дэндүү их юм мэдэж байна. Энэ хүн миний бичиг, газрын зургийг уншчихсан юм биш биз гэж би бодлоо.

- Цагаан хүн, чи надаас болгоомжлох хэрэггүй. Би чамайг унагах нүх ухахгүй.

- Энэ хүн уулсын цаадах хачирхалтай газар орны тухай ярьж байна гэж би Хенрид хэлэв.

- Тэр газар орны тухай юу мэддэг гэнэ вэ?

- Хэлэхийг хүсэхгүй байна.

- Тэр надад таалагдаж байна. Бид замдаа гарахаас өмнө энэ хүнийг авсан нь аз болсон ч байж магадгүй.

- Хэрэв чи бидэнтэй хамт явах юм бол эргэж ирэхгүй ч байж магадгүй гэдгээ мэдэх ёстой.

- Би явна аа, миний араас уйлж гашуудах хүүхэн байхгүй. Би та нартай цөлийг гаталж уулыг давна.

Тэр дахиад юу ч хэлсэнгүй, жадаа өргөж ёслоод отгийн зүг алхав.

Дөрөвдүгээр бүлэг

Ус! Ус!

Бид маргааш хөдлөхөд бэлэн боллоо. Ачаа хүргэж ирсэн хүмүүс буцсан учир Гүүд, Умбора, Хенри, Вентвогель бид нэг нэг боодол ачаа үүрэв. Би ачаа хүргэж ирэгсдийн гуравт нь анчны сайн хутга өгөхөөр тохиролцсон тул тэд эхний хорин бээр газар бидэнтэй хамт явахаар болов. Тэр гурав нэг нэг торх ус үүрлээ. Эхний шөнийн аяны дараа бид усны саваа дахин дүүргэх хэрэгтэй байсан бөгөөд шөнийн сэрүүнд аяллаа эхлэхээр шийдсэн хэрэг.

Маргааш нь бид өдөржин унтаж амрав. Тэгээд нар жаргах үеэр үхрийн махан нөөш идэж, цай уулаа. Есөн цагийн үед сар хөөрөхөд бид хөдлөхөд бэлэн болсон байв. Буу, жад үүрсэн Умбора түрүүлж, араас нь Хенри, Гүүд бид гурав, тэгээд Вентвогель нутгийн гуравтай хамт зогсоход Хенри хөдлөх тушаал өгөв.

Ингээд бид шөнийн цагаар их цөлийг гатлах гэж итгэхийн аргагүй аянаа эхэллээ.

Маргааш өдөр нь юу болсон тухай би дэлгэрэнгүй ярихгүй. Тэр өдөр нутгийн гурав буцсаныг хэлэхэд л танд хангалттай. Тэд миний амласан хутаг дээр нэмж өгөх хөлс шанг сонсохыг ч хүссэнгүй. Бид хооллож ундалсны дараа усны саваа дүргэж аваад хөдөллөө.

Өдрийн туршид бул хадны сүүдэрт юм уу, элсний хонхор руу өнхөрч унаад амсрынх нь бугаар сүүдэрлэж аваад амарч өнжив. Шатаам халуун байсан учраас унтаад сэрэхэд бие махбод жигнэгдээд болж байх шиг санагдана.

Сар мандахад босоцгоон халуун нар шарах хүртэл шөнийн цөл дундуур унан тусан урагшилж байлаа.

Гурав дахь шөнө дуусахад бид цөл дундуур тавин бээр зам туулсан байв. Де Силвестрагийн зурсан газрын зураг дээр цөлийг хөндлөнгөөрөө дөчин лиг гэж тэмдэглэсэн байсан ба тэг дунд нь “шанага муу ус бий” гэсэн байв. Дөчин лиг гэдэг нь нэг зуун хорин бээр учраас одоо бид хэрэв мөнөөх шанага муу ус байдаг бол түүнээс арван хоёроос арван таван бээр зайд ирсэн байх ёстой. Хэрэв тийм бол бид хүрэх газраа хүрэхэд бага л зай үлдсэн байгаасай гэж би дотроо залбирч байлаа.



Дөрөв дэх өдрийн оройн нарнаас өглөөний хоёр цаг хүртэл зогсолтгүй алхаад зуун фут орчим өндөр хайчин дүрстэй элсэн манхны ёроолд очуут нам унтав.

Үүрээр сэрэхэд агаар миний хэлж мэдэхгүй хачин бүгчим халуунаар толгой дээрээс дарж байх шиг санагдав. Би өндийж суугаад, халтартсан нүүрээ алгаараа илж, наалдсан уруул, зовхио салгалаа. Нар мандахад бусад маань цувран сэрлээ.

Бүгдээрээ сэрсний дараа бид тун ноцтой болоод байгаа нөхцөл байдлыг хэлэлцэв.

- Бид ус олохгүй бол бүгдээрээ үхнэ гэж Хенри хэллээ.

- Газрын зураг үнэн бол энэ хавьд ус байх ёстой гэж намайг хэлэхэд хэн ч миний үгэнд сэтгэл сэргэсэн шинжгүй байна.

Тэгээд өөд өөдөөсөө харж, хэсэг дуугүй сууцгаав. Вентвогель босч, элсэн манхны бэлээр газар ширтэн удаан алхаж байгаа харагдана. Тэгснээ гэнэт зогсоод, газар руу зааж огцом хашгирав.

- Энэ юу болоо вэ? гэлцэн бид түүн рүү хүрч очлоо.

Тэр нэг амьтны мөр харжээ.

- Хар сүүлт зээрийн шинэхэн мөр байна. Яагаад үүгээр явсан юм бол? гэж намайг гайхахад:

- Хар сүүлт уснаас их холддоггүй юм гэж Вентвогель итгэлтэй өгүүлнэ.

Би түүний хэлснийг нөхдөдөө дамжуулав.

Энэхүү жижигхэн нээлт бидний амийг аварсан юм. Вентвогель хамраа сарталзуулан агаар үнэрлээд:

- Ус үнэртэж байна гэлээ.

Тэгтэл нар мандаж, бидний гайхсандаа дүрлийсэн нүдэнд гайхамшигийг үзүүлэхэд бид ангаж цангаснаа ч мартаж орхив.

Биднээс дөрөв тавхан бээрийн зайд агуу их Сулиманы нуруу өглөөний наранд мөнгөрөн гялалзаж, хэдэн зуун бээрийн алсад сунан дүнхийж байлаа. Бидний эгц урд багаар бодоход арван таван мянган фут өндөр хоёр их уул сүндэрлэж, айж сүрдмээр цавчим хадан хясаанууд сэрийн, цасан цагаан оргил нь тэнгэрт уусан алдарч харагдав. Хоёр оргил дээр цас мөсөнд хучигдсан бөмбөлөг тавьсан юм шиг харагдана.

- Шебагийн хөх! гэсэн үг миний амнаас амьсгалтай цуг гарав.

Хоёр оргилыг тэр дороо хачирхмаар будан, үүл нөмөрч үзэгдэхгүй болголоо.

Бид ам хуурай болтол цангаснаа сая л саналаа. Вентвогель ус үнэртэж байна гэж мэдээлсэн нь үнэхээр сайхан хэрэг боловч бидэнд одоогоор ус үзэгдээгүй л байна. Эргэн тойронд бидэртэн үргэлжилсэн элсэн манхан л байх аж. Бид манхныг тойрон алхсан боловч булаг шанд юу ч харагдсангүй.

- Чи худлаа хэллээ, ус алга л байна шүү дээ гэж Вентвогельд хэлэхэд тэр гомдож:

- Надад үнэртсэн л юм даа, агаарт усны үнэр байсан гэнэ.

- Мэдээж, тээр тэнд үүл байгаа юм чинь. Харин хоёр сарын дараа л энд бороо орж, бидний ясыг угаана биз.

Хенри сахлаа бодлогошронгуй илээд:

- Уулын орой дээр ус байдгийг хэн хүнгүй мэднэ шүү дээ гэлээ.

- Очиж үзье гээд бид Умборагийн араас манхны орой өөд авирав.

Умбора орой дээр гараад:

- Энд ус байна гэж чанга хашгирлаа.

Тавдугаар бүлэг

Агуй

Бид түүний араас яаран орой дээр гараад түүний заасан зүг рүү харлаа. Манхны орой дээрх гүнзгий хонхорт худаг ч гэмээр, цөөрөм ч гэмээр ус харлан үзэгдэнэ. Бид хоромхон зуурт тэнд хүрээд, элэглэн хэвтэнгүүтээ ус залгилж гарав. Дараа нь хувцсаа тайлж шидлээд, цөөрөм дотор орж суулаа.

Бүтэн өдөр унтаж амраад, сар гармагц аянаа үргэлжлүүлээ. Хөдлөхийн өмнө сайн идэж ууж аваад, савнуудаа усаар дүүргэв. Богино хугацаанд их зам туулж, хоёр хоногийн дараа Шебагийн хөхний бэлд хүрлээ. Цөөрмөөс авч гарсан усаа ууж барсан тул маш их цангаж байлаа. Нэг том цохионы ёроолд амрахаар тухлав. Умбора гэнэт ухасхийн босоод хэд алхсанаа гартаа нэг юм бариад бидний зүг бүжиглэн гүйв.

- Юу вэ Умбора?

- Хоол, унд хоёулаа!

Тэр том гэгч амтат гуа авчирсан бөгөөд тэнд зэрлэг гуа маш их ургасан байжээ.

- Амтат гуа! гэж намайг хашгирахад Гүүд Умборагийн гараас гуаг шүүрэн авч хиймэл шүдээ зоов.

Хүн бүр зургаан гуа амтархан идэж билээ. Тэгээд сар гармагц замдаа орлоо. Бид даахынхаа хэрээр амтат гуа үүрсэн юм. Явах тусам агаар улам сэрүүсч байлаа. Үүр цайх хүртэл дөнгөж арван хоёр бээр явжээ. Тэр өдөр бид их хол явж чадсангүй. Нар гармагц орой болтол амрахаар буудалласан бөгөөд маш их даарах шинжтэй болж ирэв. Маргааш нь бид ердөө таван бээр явав. Дэндүү хүйтэн байсан учир Вентвогель, Умбора хоёрыг хөлдөж үхэх байх гэж айж байлаа.

Нар жаргахад бид уруулаа чийглээд уул өөд өгсөв. Бүтэн өдөр хоорондоо нэг ч үг дуугаралгүй явсаар нар жаргахын өмнө цасан хунгар дундах бяцхан хонхорт хүрлээ. Тэр хонхор нь зүгээр ч нэг хонхор биш, агуйн ам болохыг нэлээд хожуу анзаарсан юм. Үдшийн бүрий болох үеэр бид агуйн ам руу орж дулаацаж аваад унтаж амрав.

Шөнөжингөө шүдээ хавирсан Вентвогель нэгэнтээ гүнзгий амьсгал аваад шүдээ хави-рахаа больчихов. Тэр миний хажууд цааш харан унтаж байсан бөгөөд бие нь хөрөн хөрсөөр мөс шиг хүйтэн болохыг би мэдэрлээ.

Агуй доторхи агаар цайвартан нар гарсныг илтгэхэд бид босоод Вентвогель чулуу мэт хөдөлгөөнгүй хөлдсөнийг олж үзлээ. Цочиж балмагдсан бид хөөрхий түүний цогцсыг агуйгаас гаргаж гарыг нь өвдгөөр нь тэврүүлэв.

Энэ үед нар мандаж, хүйтэн туяа нь агуйн амыг гийгүүллээ. Гэнэт агуй дотроос хэн нэгний дуу сонсогдох шиг болоход би эргэж харлаа. Агуйн мухарт ямар нэг амьтан урт гараа

унжуулан сууж байгаа харагдав. Тэр бол үхсэн хүн, түүгээр ч үл барам цагаан арьстан байх юм.

Манайхан түүнийг хараад дуугарч ч чадахгүй боллоо. Тэгээд бид агуйгаас нэн даруй гарав.



Зургàадугаар бүлэг

Соломоны зам

Бид агуйн аман дээр яахаа мэдэхгүй алмайран зогсож байх зуур Хэнри:

- Би буцаж орлоо. Саяны цогцос миний дүүгийнх ч юм билүү яаж мэдэхэв гэлээ.

Тэгээд түүнийг агуй руу ороход бид хөдөлж ч чадсангүй, дуугарч ч чадсангүй харсаар үлдэв. Зөвхөн агуйн харанхуй руу нүдээ бүлтийлгэн ширтэхээс өөр юу ч хийж чадсангүй. Хэнри агуй дотроос:

- Өө, энэ чинь миний дүү байна шүү дээ, бурхан минь танд баярлалаа гэж хашгирах дуулдав.

Тэгэхэд нь би агуй руу ороод түүний дэргэд очиж өвдөглөн суугаад цогцсыг анхааралтай ажиглав. Тэр бол ид дунд насны, өндөр хүн байлаа. Урт ургасан үс нь ширэлдэж, арьс нь ясандаа наалдаж хатсан байна. Цогцос дээр хувцасны үлдэгдэл ноорч, өмхөрчээ. Хүзүүнд нь зааны ясан зүүлт байлаа.

- Энэ яг мөн үү? гэж намайг асуухад Хэнри,

- Энэ бол миний дүү биш, хөгшин Хосе де Силвестра мөн гэдэгт би бат итгэлтэй байна гэв.

- Итгэхийн аргагүй юм. Тэр хүн чинь гурван зуун жилийн өмнө үхсэн биз дээ.

- Гэвч эндэхийн нөхцөлийг гурван мянган жилийн турш хэн ч өөрчлөөгүй шүү дээ. Түүний боол эзнээ нас барахад энд орхиод явсан байна. Ганц хүн оршуулахад хэцүү байсан нь илэрхий байгаа биз дээ гэж тэр хэлээд шарилын дэргэд байсан хурц үзүүртэй нарийхан ясыг авч надад үзүүлээд,

- Энэ ясаар тэр захидал бичиж, зураг зурсан байна гэлээ.

Бид түүний үгэнд үнэмшиж, шарилыг гайхан ширтэв. Тэгээд гурван зуун жилийн өмнө талийгаач болсон тэр эрхэм хүн биднийг энэ газарт авчирсанд туйлын ихээр талархаж билээ. Гүүд мөнөөх ясан үзгийг удтал харж байснаа,

- Талийгаач нас барахынхаа өмнө үзгээ үнссэн байна гэж хэлэв.

- За явцгаая даа. Энэ эрхэм хүнд дуугүй зогсож хүндэтгэл үзүүлье гэж хэлээд Вентвогелийн шарилыг хөгшин Хосегийн дэргэд тавих санал гаргав.

Би ясан үзгийг өөртөө авсан бөгөөд чухал баримт бичигт гарын үсэг зурахдаа түүнийг хэрэглэдэг юм.

Бид агуйд хоёр шарилыг орхиод нарны гэрэлд гарч аяны замаа үргэлжлүүлэв. Хагас бээр орчим яваад өндөрлөгийн захад ирлээ. Өглөөний манан эргэн тойрныг бүрхсэн тул өндөрлөгийн дор юу байгааг бид харсангүй. Гэвч хэсэг байзнаад манан шингэрэхэд бидний

байгаа газраас таван зуун ярд хэртэй зайд цасанд хучигдсан урт нуруу үргэлжилж, ногоон зүлгэн дундуур нарийхан гол урсаж үзэгдэв. Голын дэргэд сүрэг хар сүүлт зээр бэлчиж байна. Агнаж чадаж гэмээнэ үнэхээр сайхан хүнс бэлэн байлаа.

- Эднээс нэгийг унагаах гэж оролдоод үзье гэж ноён Хенри хэлэв. Бидний гурав нь бугаа барин, зээрийн сүрэг рүү гэтэн ойртоод нэгийг нь унагаж амжив. Гал түлэх боломж байгаагүй учир бид зээрийн мах түүхийгээр нь идэж, мөс шиг хүйтэн булгийн ус залгилав. Арван таван минутын дараа бид цөм хүч чадал сэргэж, дахин төрсөн мэт боллоо.

- Бурхан тэнгэрт талархъя. Энэ ан бидний амийг аварлаа гэж Хенри өгүүлэв.

Умбора ангийн махыг эвдэж, бид даахын хэрээр үүрцгээв. Манан сарниж, тэнгэр цэв цэлмэг болоход бид эргэн тойрноо сайн харж авлаа. Үзэсгэлэн төгс байгаль биднийг хүрээлж, өтгөн ой ногоорон сүглийж, өргөн мөрөн мөнгөрөн зурайж байна. Зүүн талд өндөр ургасан өвс ногоотой дэнж дээр олон үхэр бэлчинэ. Баруун талд урт нуруу үргэлжилж, тариалангийн газар харагдах бөгөөд тэнд бас хэдэн урц хэлбэрт байшин үзэгдэв.

Бид байгалийн сайхныг бишрэн, хэсэг чимээгүй суулаа.

- Газрын зураг дээр Соломоны зам байсан билүү? гэж Хенри асуув.

Би үзэсгэлэнт байгалиас нүд салгаж чадсангүй тул дуугүй толгой дохив.

- Хараач, тэр их зам энэ байна, гээд Хенри баруун тийш заав.

Дэнж дээгүүр өргөн дардан зам зурайж байлаа. Бид босож, тэр зүг алхлаа. Нэг бээр орчим яваад зам дээр гарлаа. Гэвч бидний урд наад зах нь тавин фут өргөн том хадан цохио хөндөлсөв.

- Энэ зам тэр нурууг даваад цөл рүү орно, цөлийн элс замыг бүрхсэн учир харагдахгүй байжээ. Харин энэ хэсэгт галт уулын дэлбэрэлтээр зам хаагдсан юм байна гэж Гүүд хэлэв. Бид замаар уул өөд өгсөхөд уур амьсгал улам зөөлөн, дулаан болж байлаа. Үд дунд зам ой руу оров.

- Энд сайхан түлээ байна, буудаллаж, хоол хийж идэцгээе гэж Гүүд санал гаргав.

Бид замаас гарч, голын захад хүрээд, хуурай мод түлж, зээрийн мах шарж идлээ. Би нэлээд ядарсан тул дээш харан хэвтээд Умбора, Хенри хоёр хазгай муруй англи, хагас дутуу зулу хэлээр ярилцах гэж оролдохыг нь чагнаж байв. Гүүд голын усанд шумбаж харагдав. Тэр бүх хувцсаа тайлж, эрэг дээр эвхэж тавиад, гутлаа тайлж өвсөөр арчаад зээрийн өөхөөр тослов. Тэгснээ жижиг цүнхнээсээ үсний сам гаргаж ирээд нүдний шилэндээ нүүрээ тольдов. Тэгээд арав хоног хусаагүй сахлаа илбэж үзлээ.

- Арай сахлаа хусах гэж байгаа юм биш биз гэж намайг бодох зуур тэр үнэхээр сахлаа хусч эхлэв. Гутлаа тосолсон өөхийг голд нямбайлан угаагаад, сахлаа тосолж, цүнхнээсээ сахлын хутга гарган сахлаа хусч эхэлсэн боловч өтгөн хууз сахал нь мохоо иртэй сахлын хутганд

даагдахгүй зовоож байгааг нь хараад инээдээ барьж ядан байтал гэнэт түүний толгой дээгүүр гэрэл гялсхийв.

Гүүд дуу алдан босч харайхад би ч нүд ирмэх зуурт хөл дээрээ боссон байлаа. Биднээс хориод алхмын зайд гартаа жад барьсан хэдэн хүн гараад ирсэн байна.

Долоодугаар бүлэг

Оддын хөвгүүд

Тэр өндөр эрчүүд цөм зэс мэт хүрэн улаан арьстай байв. Тэд барын арьсан богино дээлтэй, зарим нь толгой дээрээ өд хатгажээ. Арван долоо орчим насны залуу хөвгүүн урд нь явах бөгөөд хамаг бие нь үсрэх гэж байгаа мэт хөвчирч, нэг гараа өргөжээ. Тэр дөнгөж сая жадаа шидсэн нь надад гэрэл гялсхийх шиг харагдсан аж. Тэгтэл нэг өвгөн хүн урагш давшин гарч ирээд хөвгүүний гараас барьж, бидэн рүү ирлээ.

Умбора, Гүүд, Хенри гурав буугаа шүүрэн тэдний өөдөөс чиглүүлэхэд би:

- Буугаа буулга гэж тушаав.

Манай нөхөд миний үгээр буугаа буулгахад би нөгөө өвгөн рүү очоод яриа үүсгэв:

- Мэнд хүргэе гэж би зулу хэлээр хэлэхэд өвгөн:

- Мэнд хүргэе гэж зулу хэлтэй ойролцоо аялгаар хариу хэлэв.

- Та нар юун хүмүүс вэ?

- Та гурав цагаан байхад яагаад энэ бидэнтэй адил байгаа юм бэ? гэж өвгөн Умбора руу заав.

- Бид танай газарт аялж ирсэн хүмүүс. Бид сайн санаа өвөрлөж ирсэн, харин таны ээжийн хүүтэй адил энэ хүн бол бидэнд үйлчилж яваа юм гэж би хариулав.

- Хэрэв та нар аялж яваа юм бол үхэх ёстой. Кукуанасын газарт тэнүүлчид гишгэх ёсгүй. Энэ бол хааны хууль гэж өвгөн хэлэхэд эрчүүд нь жадаа өргөв.

- Энэ юу гэж хэлэв? гэж Гүүд асууна.

- Биднийг ална гэж хэллээ.

- Ээ бурхан минь! гэж Гүүд халаглав. Тэр сандрахаараа хиймэл шүдээ авч, буцааж амандаа хийгээд эрүүгээ тасхийтэл дуугарган шүдээ байранд нь оруулдаг зуршилтай ажээ. Тийнхүү шүдээ гаргаж ирэхэд нь кукуанасчууд хирдхийн цочиж, арагш хэдэн алхам ухрав.

- Чи шүдээрээ эднийг айлгачихлаа. Шүдээ дахиад гарга гэж Хенри шивнэв.

Гүүд шүдээ авч, цамцныхаа ханцуйд шургуулав. Төдөлгүй зориг айдсыг давж, өнөөх эрчүүд аажмаар дөхөн дан цамцнаас өөр хувцасгүй, сахлаа дутуу хуссан, нүүрнийхээ нэг талд үстэй, нөгөө талдаа үсгүй, нэг нүдэнд нь шил гялалзаж, нөгөө нүд нь бүлтийсэн, шүд нь амнаасаа гарч ирээд буцаад орчихдог Гүүд рүү заацгааж байлаа.

- Амаа ангай! гэж би Гүүдэд хэлэв.

Тэр амаа байдгаараа ангайн уурласан нохой шиг архирахад кукуанасчууд балмагдаж:

- Шүд нь хаашаа алга болчихов оо? хэмээн хашгиралдав.

Гүүд гараа ам руугаа хийгээд дахин амаа ангайхад шүд нь байрандаа орсон байлаа.

Жад далайсан залуу хөвгүүн зүлгэн дээр унаад айсандаа чанга хашгирахад өвгөн өвдөг сөгдөөд:

- Та нар тэнгэрс юм байна. Нүүрнийхээ нэг талд үстэй, нөгөө талдаа үсгүй, дугариг шилэн нүдтэй, шүд нь өөрөө гарч ирээд, буцаад орчихдог хүн яаж байх билээ. Биднийг өршөөж хайрла тэнгэрс минь гээд мөргөв.

Ийм азтай тохиолдлыг би дор нь шүүрэн авч:

- Та нар бидний сүр хүчийг нэгэнт мэдсэн болохоор бид та нарыг өршөөнө. Та нарт үнэнийг хэлье гээд тэнгэр өөд зааж:

- Бид шөнө болохоор гэрэлтдэг хамгийн том одноос энд бууж ирсэн юм гэхэд кукуанасчууд “Оох- хоо” хэмээн нэгэн дуугаар хашгиралдав.

- Бид та нартай түр зуур хамт байж, та нарыг ивгээнэ. Би та нарын хэлийг шууд л сурсан байгаа биз дээ? гэж намайг хэлэхэд тэд “Тийм, тийм” гэж нэгэн дуугаар батлав.

- Тэнгэр минь, гэхдээ та их л муу сурсан байна даа гэж өвгөнийг хэлэхэд би түүн рүү муухай харав. Өвгөн айж алхам ухарлаа.

- Би яарсан болохоор сайн сураагүй гэж түүнд хүйтэн өнгөөр хэлээд, - Одоо найзууд минь, биднийг алах санаа агуулсан хүн өөрөө үхэх болно шүү гээд би нөгөө жад шидсэн залуу руу заав.

- Тэнгэр минь, түүнийг өршөөж хайрла. Энэ бол хааны хүү, би авга ах нь байгаа юм. Түүнд муу юм тохиолдвол би цусаараа хариуцах учиртай гэж өвгөн хэлэхэд “Тийм, тийм” гэж залуу батлав.

- За тэгвэл та нарын дотор бидний сүр хүчинд эргэлзэж байгаа хүн байгаа бол би үзүүлээд өгье гээд би Умбора руу эргэж “Миний бууг өгөөрэй” гэж дохих зуураа:

- Муу боол нохой, чи миний шидэт савааг өгөөд орхи гэхэд Умбора доор гэгч бөхийн ёслоод:

- Эздийн эзэн та минь, таны шидэт саваа энэ байна гээд бууг надад өгөв.

Биднээс далаад ярдын зайтай цохион дээр нэг гөрөөс зогсож байгааг би харсан юм. Би тэр зээр рүү заагаад:

- Тэнд юу байна? гэж асуухад:

- Гөрөөс байна аа, эзэнтэн минь, миний дайчид түүнийг танд авчирч чадна гэж өвгөн хариулав.

- Хэрэггүй ээ, харин эхээс төрсөн эр хүн тэр зээрийг эндээс чанга дуу гарган алж чадах уу? гэж намайг хэлэхэд дайчид өөр хоорондоо ярилцаж инээлдээд:

- Тийм боломж байхгүй ээ эзэн минь гэцгээв.

- Тэгвэл би чадна гэхэд өвгөн инээмсэглэж:

- Эзэнтэн та ч бас чадахгүй байх аа гэв.

Би буугаа өргөж, зээрийг хараалав. Алдаж огт болохгүй гэж би өөртөө тушаагаад гүнзгий амьсгаа авч, бууны гохыг аажуухан татлаа. Гөрөөс хөдөлгөөнгүй зогссоор л байв.

Буу тасхийхэд гөрөөс агаарт үсрээд цохион дээр нам унав. Дайчид айсан дуугаар хашгиралдана.

- Та нарт мах хэрэгтэй бол гөрөөсийг төхөөрч ав гэж би хүйтнээр хэлэв.

Өвгөн дохио өгөхөд дайчдын нэг нь цохио өөд авирч, гөрөөсийг үүрч ирэв. Дайчид гөрөөсийг тойрон харж, сумны нүхийг үзээд гайхан дуу алдацгаана.

- Би хоосон үг хэлдэггүйг та нар үзлээ. Одоо бидний хүчинд итгэхгүй хүн байвал тэр цохион дээр очоод зогсож болно. Би энэ гөрөөс шиг болгоно гэхэд дайчид гараа өргөн ухарцгаалаа.

- Сайн ид шидийг хөөрхий бидний бие дээр дэмий үрээд хэрэггүй дээ гэж нэг дайчин хэлэв.

- Манай бүх шидтэнгүүд ийм юм үзүүлж чадахгүй гэж нөгөө нь хэлэхэд өвгөн:

- Үнэхээр тийм шүү. Тэнгэрийн хөвгүүд минь намайг сонс, би бол Кукуана, хүмүүсийн хаан Кафагийн хүү Инфодоос байна. Энэ залуу бол Скрагга гэж танилцуулав.

Скрагга бол мянган эхнэрийн нөхөр, Кукуанагийн эзэн, их замын эзэн, дайснуудынхаа аймшиг, хар урлагийг эзэмшигч, нэг зуун мянган дайчны удирдагч, ганц нүдэт, хар айдаст Твалагийн хүү ажээ.



- Тэгвэл биднийг тэр Твала дээрээ хүргэж өг, бид доодостой ярихгүй гэж би ихэмсгээр өгүүллээ.
 - Тэгэлгүй яахав, эзэн минь, би та нарыг Твала дээр хүргэж өгнө. Тэр та нарын ид шидийг үзэг. Гэхдээ их урт зам туулна даа. Бид хааны байгаа газраас гурав хоног явж энд ирсэн.
 - Бид бэлэн байна, дагуулаад яв. Гэхдээ Инфодоос минь, Скрагга минь ухаантайхан байж үзээрэй дээ. Бидэнтэй сармагчингийн тоглоом тоглосны хэрэггүй шүү, шидэт саваа ганц чанга дуугарахад та нарын бие нүх болно гэж мэдээрэй.
 - Эзэд минь, өршөөж хайрла, бид та нарыг хүргэж өгнө гэж өвгөн гүнээ мэхийн бөхөлзөв.
- Тэгээд дайчдадаа нэг юм хэлэхэд цаадуул нь бидний бүх ачааг үүрсэн боловч буунд гар хүрэхээс ч айж байлаа. Тэд бүр Гүүдийн боож үүрсэн хувцсыг ч авлаа. Гүүд уурлаж:
- Хувцсыг минь өгөөд орхи, би өөрөө авч явна гэж хашгирахад Умбора орчуулж өгөв.
 - Гялалздаг нүдтэй эзэнтэн минь, таны юмыг боолууд чинь авч явах ёстой. Харин эзэнтэн та гоё цагаан хөлөө боолуудын нүднээс далдлахгүй юу? гэж Инфодоос асуув.

Дайчдын нэг нь түүний хувцсыг авахад Гүүд:

- Энэ муу зэрлэг миний богино өмдийг авчихлаа хэмээн уурлахад нь би инээдээ арайхийн барьж:

- Сонс Гүүд, би эдэнд “Бид тэнгэрээс бууж ирсэн” гэж хэлсэн. Эд нар одоохондоо үнэмшиж байна. Эд чамайг агуу их шидтэн хэмээн итгэж, чиний “Гоё цагаан хөл”- ийг биширч байна. Намайг уучлаарай, гэхдээ чи богино өмдөө өмсөх хэрэггүй. Чи нэг талынхаа сахлыг хусаад нөгөө талынхаа сахлыг хусаагүй байгаа. Би чамаас уучлаарай гэж гуйсан шүү дээ, гэхдээ энэ чигээрээ байсан нь дээр. Хэрэв эд биднийг тэнгэрээс буугаагүй гэж мэдэх л юм бол бидний амь ингэх төдийд дуусна гээд би хуруугаа инчдэв.

- Эд нар үнэхээр тэгж бодож байгаа юм уу? гэж Гүүд асуулаа.

- Үнэхээр тийм, чиний хиймэл шүд, гоё цагаан хөл, нүдний шил чинь бидний дүр төрх учраас чи энэ хэвээрээ л бай. Гутлаа өмсчих, тэгээд цаг агаар дулаан байгаад таларх гэхэд тэрээр гутал руугаа харснаа “Ээ бурхан минь” гэж дуу алдаад цамцныхаа хормойгоор гуяа далдлан, хурдхан шиг алга болсон богино өмднийхөө араас шогшив.

Наймдугаар бүлэг

Твала хаан

Бид үдээс үдэш болтол баруун хойт зүгийг чиглэн их замаар алхав. Инфодоос бидний хажууд алхаж байсан тул би түүнээс энэ замыг хэн тавьсан юм бэ гэж асуулаа.

- Хэн ч мэддэггүй юм аа, эзэн минь, асар урт насалсан хамгаас мэргэн Гагоон эмгэн ч энэ талаар юу ч мэдэхгүй.

- Какуана нар энэ газарт хэзээ ирсэн бэ?

- Эзэн минь, алс холын орноос тэднийг энд ирснээс хойш арван мянган сар гарсан - гээд хойт зүг рүү зааж, - Уулс тэднийг цааш нь явуулаагүй учир тэд энэ оронд суурьшсан юм. Тэгээд олон он жил өнгөрөхөд тэд хүчирхэг болсон. Твалагийн дайчид нүдний хараа гүйцэх газрыг бүрхэхээр тийм олон болсон.

- Танай дайчид олон дайн хийсэн үү?

- Ердөө ганцхан дайн болсон, иргэний дайн байсан юм.

- Яагаад дайн болсон юм бэ?

- Миний эцэг Кафа хаан гурван хүүтэй. Твала Имоту хоёр нэг өдөр нэг эхээс төрсөн ихэр хоёр. Манай заншлаар ихэр хүүхдүүд амьдрах ёсгүй, аль сул доройг нь хөнөөдөг юм. Гэвч эх нь хүүхдээ нууж өсгөсөн нь Твала хаан. Би бол эцгийнхээ өөр эхнэрээс төрсөн.

- Тэгээд яасан?

- Миний эцэг Кафа хаан нас барахад миний ах Имоту түүний оронд хаан болсон. Тэр бас хүүтэй, хүүг нь Игноси гэдэг байсан. Хүү нь гурван настай байхад Имоту тулалдаанд шархадсан юм. Тэгэхэд үхэшгүй мөнх настай хамгаас мэргэн эмэгтэй Гагоол төрсөн цагаас нь агуйд нууж байсан Твала хүүгээ дагуулж ирсэн юм. Тэр хүүдээ могойн тэмдэг тавьсан байсан. Хааны ууган хүүд тийм тэмдэг тавьдаг юм л даа. Тэгээд бүх хүмүүсийн өмнө “Эзэн хаанаа хүлээж ав, би хааныг тань өнөөдрийг хүртэл нууж байлаа” гэж хашгиран зарласан.

- Хүмүүс яагаад Имотуг хаан болгоогүй юм бэ?

- Тэд Гагоолоос айсан юм, эзэн минь. Тэгээд л цөм “Хаан, хаан” гэж хашгиралдсан.

- Тэдний хашгиралдахыг сонсоод Имоту өргөөнөөсөө гарч ирээд “Юун шуугиан болоод байна? Би та нарын хаан шүү дээ” гэж хэлсэн. Тэгтэл түүний ах Твала түүн рүү гүйж очоод үсдэж авангуутаа зүрхэнд нь илд дүрээд “Үгүй ээ, би хаан байна” гэж хашгирахад хүмүүс гараа өргөн “Твала хаан” гэж хашгиралдсан. Тэгээд л өнөөг хүртэл хаан сууж байгаа юм даа, эзэн минь.

- Имотугийн эхнэр, хүү Игноси нь яасан бэ? Твала бас алсан уу?

- Үгүй ээ, эзэн минь, тэр хүүгээ аваад зугтааж амжсан. Хоёр хоногийн дараа тэр хоёр отогт ирэхэд хүмүүс түүнд хоол өгөөгүй. Гэвч шөнө дунд нэг жаахан охин тэр хоёрт хоол авчирч өгөхөд тэр охиныг адислаад хүүхдээ авч уул руу явсан. Тэр цагаас хойш түүнийг хэн ч хараагүй, хүүхдийг нь ч бас хараагүй.

- Хэрэв Игноси амьд байгаа бол кукуанас хүмүүсийн жинхэнэ хаан нь болох ёстой биз дээ?

- Тийм ээ, эзэн минь, тэр амьд байгаа бол хаан болох ёстой. Түүний биед ариун могойн тэмдэг байсан. Даанч байхгүй болоод удаж байна.

Тэр агшинд би Гүүдэд юм хэлэх гээд эргэж хартал яг миний ард Инфодоос бид хоёрын яриаг асар их сонирхон чагнаж явсан Умборатай мөргөлдөв. Түүний царай маш ноцтой, мартаад удсан ямар нэг юм сэргээн санах гэж хичээж байх шиг харагдана.

Бид Соломоны их замаар хоёр хоног явж, кукуана газрын төв дунд орж ирлээ. Хоёр дахь өдрийн нар жаргах үеэр бид нэг өндөрлөг газарт амрахаар буудаллав. Твала хааны суудаг Лоо гэдэг газар урдхан талд байлаа. Тэр бол эргэн тойрон таван бээр орчим уудам дэнж бөгөөд хойт зүгт хоёр бээр орчим зайтай адууны нуруу хэлбэртэй урт нуруу, барагцаагаар жар далан бээрийн зайд гурван цаст оргил дүнхийж байв.

Нэг цагийн дотор бид олон мянган гал түлсэн их хуаран хотод орж ирэв. Тоймгүй олон өвс, модон урцтай төв гудамжаар нь явсаар хамгийн том урцны өмнө очив. Тэр бол бидний байрлах урц ажээ.

Сайхан үнэртэй өвсөн гудсан дээр ангийн арьс дэвссэн ор байх бөгөөд бид угаал үйлдсэний дараа нэгэн залуу эмэгтэй модон царан дээр чанасан мах, ногоо авчирч өглөө.

Бид удаан аялж ядарсан тул сайн идэж ууж аваад шууд унтлаа.

Сэрэхэд нар өндөрт мандсан байв. Гар нүүрээ угаагаад өглөөний цай ууж байх зуур Твала биднийг хүлээж авахад бэлэн байна гэсэн хэл ирэв. Бид байгаа бололцоогоороо түүнд бэлэг бэлдэж, хөөрхий Вентвогелийн хэрэглэж байсан винчестер бууг хэдэн сумтай Твалад өгч, эхнэрүүдэд нь хэдэн хув, шилэн эрих өгөхөөр болов. Тэгээд Умбора бэлгээ авч, Инфодоос дагалдан бид хааны урц руу очлоо.

Асар том хашаан дотор хааны эхнэрүүдийн урц, нөгөө талд нь хааны суудаг том урц байна. Жад, бухын арьсан бамбай барьсан олон дайчид эгнэн зогсчээ.

Твалагийн урцны өмнө хэдэн урт сандал тавьсан харагдана. Бид Инфодоосын дохиогоор гурван сандал дээр сууж, Умбора бидний ард зогслоо. Инфодоос хаалганы дэргэд зогсч, бид арван минутын турш чив чимээгүй хүлээж байхад найман мянган хос нүд биднийг цавчих ч үгүй ширтэж байсан юм шүү. Тэгтэл хаалга нээгдэж, барын арьс мөрөн дээгүүрээ хөдөрсөн аварга том бие гарч ирэхэд арьс нөмөрсөн сармагчин шиг бас нэг амьтан харагдав. Түүний араас Скрагга дагажээ. Тэр аварга биет нэг сандал дээр сууж, Скрагга ард нь зогсов. Сармагчин шиг амьтан сүүдэрт шууд дөрвөн хөллөн хэвглээ.

Анир чимээгүй хэвээр, аварга биет барын арьсан нөмрөгөө авч бидний өмнө зогсоход үнэхээр аймаар байсан бөгөөд түүний нүүр царай урьд өмнө хэзээ ч тааралдаж байгаагүй тийм муухай юм. Зузаан уруул, хавтгай хамар, ёлтгоносон өрөөсөн нүд, /нөгөө нүдний аяга хоосон нүх байв/ зэвүүн муухай харц гээд авах юм алга. Том толгой дээр нь дэлбэгэр том цагаан өд хатгаастай, биедээ арьсан хуяг өмссөн, гартаа урт жад барьсан байв. Хүзүүндээ бүдүүн алтан гинж зүүж, духан дээр нь ер бусын том очир эрдэнэ гялалзана.

Твала жадаа өргөхөд найман мянган жад дээш өргөгдөж, найман мянган хоолой “коом” хэмээн нэгэн дуугаар хашгирлаа. Ийнхүү гурвантаа давтахад газар доргиж байв.

- Хүмүүс ээ, эмээцгээ! Хаантан ирлээ гэж сүүдэр дундаас нөгөө сармагчин шиг амьтан нарийн хоолой хашгирахад найман мянган хоолой “Хаантан ирлээ” хэмээн давтлаа.

Дахиад нам гүм боллоо. Гэтэл бидний зүүн талд нэг цэрэг бамбайгаа унагахад Твала тэр зүгт өрөөсөн нүдээрээ эргэж хараад “Урагшаа гараад ир” гэж аянга нижигнэх мэт сүртэй чангаар архирав.

Нэг дайчин жагсаалаас гарч хааны өмнө мэхийв.

- Чи бамбайгаа унагасан уу, муу нохой? Чи энэ аянчдын өмнө намайг гутаах гээ юу? Тийм үү?

- Алдас боллоо, их эзэн минь!

- Тэгвэл чи гаргасан алдаагаа амиараа төлөх болно. Үхэхэд бэлд!

- Би их эзний боол билээ.

- Скрагга, жадаа яаж ашигладгийг чинь үзье. Энэ муу нохойг ал!

Скрагга урагш гарч, жадаа өргөв. Хөөрхий золиос нь алгаараа нүдээ таглан зогсоно.

Есдүгээр бүлэг

Мэргэн эмгэн Гагоол

Скрагга жадаа хоёронтаа эргүүлээд нөгөө дайчны цээжийг нэвт сүлбэн алав. Хүмүүс нэгэнтээ дүнгэнэлдсэнээ нам гүм болов. Ноён Хенри босч ирлээ.

- Сайхан хатгалт байлаа. Үүнийг зайлуул гэж хаан хэлэв.

Дөрвөн залуу дайчин гарч ирээд хөөрхий золиосыг авч явахад:

- Цусны толбыг арилга. Хааны цаг ойрхон боллоо гэж сармагчинтай адилхан амьтан төмөр шиг царгиа дуугаар хэллээ.

Нунтаг шохойтой сав барьсан нэг охин газар дээрх цусан толбо дээр шохой асгалаа.

Ноён Хенри хилэгнэсэн хэвээр зогсохыг хараад би:

- Доош суухгүй бол бид амиа алдах байх шүү гэж түүнд шивнэв.

Тэр миний үгийг сонсоод доош суулаа. Твала ямар ч аллага болоогүй юм шиг бидэнд хандаж:

- Мэнд хүргэе, цагаан хүмүүс ээ гэхэд нь би босч:

- Кукуанагийн хаан Твалад мэнд хүргэе гэлээ.

- Цагаан хүмүүс та нар хаанаас ирсэн, ямар хэргээр явж байна?

- Би тэнгэрийн орноос буусан, танай газрыг харж, мэдэх гэж ирсэн.

- Та нар бага юм үзэх гэж их холоос ирж дээ. Энэ хүн бас одноос ирсэн үү? гээд Умбораг заав.

- Тийм ээ, дээд тэнгэрт бас та нартай адил хүмүүс байдаг юм. Гэхдээ хаантан минь, ойлгоход дэндүү өндөрдөх тул асуухгүй байсан нь дээр шүү гэж би анхааруулав.

Твала сүрдүүлэх аястай урагш бөхийж:



- Цагаан хүн чи чанга дуу гаргаж байна. Би чамайг саяных шиг алаад хаячихвал яах вэ? гэхэд би тачигнатал хөхөрсөн боловч зүрх бэмбэлзэж байв.

- Болгоомжтой байж үзээрэй, хаантан, эд нар танд бидний хүч чадлыг хэлээгүй юм уу? гээд Скрагга, Инфадос хоёр руу заав.

- Та нар их чимээ гаргаад алдаг гэж надад ярьсан, гэхдээ би үнэмшихгүй байна гээд тэр дайчид руугаа хайхрамжгүй байдлаар зангаж:

- Эднээс нэгийг нь алаад орхи, тэгвэл би та нарыг хоосон үг хэлдэггүй юм байна гэж үнэмшье.

- Үгүй ээ, бид шийтгэхээс өөр тохиолдолд хүний цус урсгадаггүй. Харин чи хүмүүстээ тушаал өгч нэг бух авчруулаад отгийн хаалганы дэргэд тавих юм бол би хорь алхаагүй байхад нь би нам болгоно.

Твала муухай хөхрөөд:

- Юу гэлээ гэнэ ээ? Харин ч үгүй шүү, хүн албал л би үнэмшинэ гэлээ.

- За яахав, тэгэхээс. Чиний хүү Скрагга тэр задгай газар алхаж байг, би алья гээд буугаа өргөхөд Скрагга огцом хашгирах шиг болсноо урц руу гүйж оров.

Твала ихэд урам нь хугарсан шинжтэй муухай царайлан, ойролцоо байсан хоёр дайчинд “Нэг залуу бух аваад ир” гэж тушаав. Хоёр дайчин гүйж одоход би Хенрид хандаж:

- Тэр хоёр бух авчрахаар явж байгаа юм. Тэр бухыг буудна гэж би хэлсэн. Харин одоо чи буудах хэрэгтэй. Тэгэхгүй бол эд нар ганцхан намайг шидтэй гэж бодох байх гэв.

Хенри буудахад бэлэн болов.

- Эхний сумаа алдчихвал дахиад буудаарай. Зуун тавин ярд ойртуулаад хажуу талаараа эргэхэд нь бууддаг юм шүү.

Хэсэг азнасны дараа хүмүүс шуугилдаж, нэг бух хаалгаар давхин орж ирлээ. Асар олон хүний бараа хараад улангассан бух дороо зогсоод толгойгоо сэжсэнээ бүтэн эргэхэд буу дуугарлаа.

Бух гэдэргээ харан унахад гайхаж биширсэн хүмүүс дуу алдах нь сонсогдов. Би хэнэггүй царайлан эргэж:

- Би худлаа хэлсэн байна уу, хаантаан? гэж асуулаа.

- Үгүй ээ цагаан хүн, энэ үнэн байна.

- Твала чи сонс, бид эв найрамдлыг өвөрлөж ирсэн. Үүнийг хар гээд винчестер буугаа үзүүлж:

- Энэ шидэт саваагаар чи ан хийж болно. Би үүнийг чамд өгч байна. Харин чи хүн рүү шагайх юм бол энэ чамайг өөрийг чинь ална шүү.

Тэр бууг ихэд хүндэтгэн аваад хөлийнхөө хажууд тавилаа. Тэгтэл нөгөө сармагчинтай адилхан амьтан урцны сүүдэр дотроос гарч ирээд хааны дэргэд очиж зогсохдоо нүүрээ бүтээсэн ангийн үсийг авлаа. Тэр бол сэжиг хүрэм хачин царайтай, шаргал өнгөт үрчлээгээр дүүрсэн тийм гэхийн аргагүй хөгшин эмэгтэй байсан бөгөөд цасан цагаан хөмсөг дор нь хар нүд ёлтгонож, үрчлээт нүүрнийх нь арьс могойн хайрс шиг хөдөлж байв.

Нуруун дээгүүр шоргоолж гүйх мэт бие ширвээтэв. Хөгшин эмэгтэй хахирган нарийхан дуугаар ярьж эхлэв:

- Сонсогтун, хаантан минь. Сонсогтун дайчид минь. Амьдралын хүч надад мөнхөрч би зөнч болсон юм. Цус. Цус. мөрөн гол шиг их цус. Хаа сайгүй цус. Би тэрнийг харж байна, үнэрлэж байна, амталж байна. Хөлийн чимээ, хөлийн чимээ. Алс газраас цагаан хүмүүс ирж байна.

Тэр бидэн рүү халзан толгойгоо эргүүлж, хуруугаараа чичлэн:

- Одноос ирсэн цагаан хүмүүс та нар энэ газарт юу эрж яваа юм бэ? Төөрсөн хүн хайж байна уу? Тэр энд байхгүй. Та нар гялтгар чулуу авах гэж ирсэн шүү дээ. Би мэдэж байна гэв.

Тэгснээ Умбора руу эргэж, хуруугаараа чичлэн,

- Хар арьстай бардам царайтай чи ч гэсэн энэ газарт юу хайж яваа юм бэ? Чи гялтгар чулууны хойноос ирээгүй. Би чамайг таньж байна. Би чиний судсан дахь цусны үнэрийг үнэрлэж чадна гэж хашгираад тэр хачин эмгэн гараа хоолой руугаа явуулснаа цагаан хөөс цахруулан газарт унаж тийчлэхэд дайчид урц руу авч оров.

Хаан босч, гараа нэгэнтээ дохиод хэдэн мянган дайчид хэдхэн мөчийн дотор нүдэнд үзэгдэхгүй болж, тэр том талбай дээр бид хэдээс гадна хаан хэдхэн хамгаалагчтайгаа үлдэв.

- Цагаан хүмүүс, та нарыг би алья гэж бодож байна. Гагоол хачин үгс хэллээ гэж Твалаг хэлэхэд би инээж:

- Болгоомжтой байгаарай даа, хаантан минь. Биднийг алахад тийм амархан биш шүү. Бух яахыг харсан биз дээ. Шидэт саваа ярьдаг юм шүү.

- Хааныг сүрдүүлэх чинь сайн юм биш шүү.

- Бид сүрдүүлж байгаа юм биш, зүгээр л үнэнийг хэлж байна. Биднийг алах гэж оролдоод үзэхгүй юу, тэгээд мэдэх болно.

- Эв зүйгээр сал даа гэж тэр сунжруулан хэлээд, - Өнөө шөнө их шулмын ан хийнэ, охидын бүжиг ч болно. Та нар үзэх хэрэгтэй. Айсны хэрэггүй. Би яахаа бодож байж маргааш шийднэ.

- Сайн байна, хаантаан гэж би хэнэггүйхэн хэлэв.

Хаан урц руугаа ороход Инфодоос түүнийг дагаад яв гэж дохилоо. Бид отгийн хаалга хүрээд би эргэж хартал Умбора хааны урцны үүдэнд зогссон хэвээр, дотогш харж байлаа. Тэгснээ жадаа өргөж, заналхийлсэн маягтай дохиод бидэн рүү алхаж ирэв.

Аравдугаар бүлэг

Игноси эргэж ирэв

Урцандаа эргэж ирээд би Инфодоост хэлэв:

- Твала их хүйтэн сэтгэлтэй хүн шиг санагдаж байна.

- Тийм ээ, эзэнтэн минь, тийм шүү. Өнөө шөнө их олон хүн шулмын анд амиа алдана. Газар дэлхий хүртэл Тваагийн хүйтэн сэтгэлд харамсан уйлах болно.

- Яагаад хүмүүс түүнийг хаан ширээнээс нь түлхэн унагадаггүй юм бэ?

- Тэр үхэх юм бол түүнээс илүү хүйтэн сэтгэлтэй хүү нь хаан ширээ залгамжилна шүү дээ. Имоти алуулаагүй байсан бол, түүний хүү Игноси амьд байсан бол байдал арай өөр байх байсан юм. Гэхдээ тэд хоёулаа байхгүй.

- Та нар Игносийг үхсэн гэж яаж батлах юм бэ? гэсэн нэг дуу гарахад бид эргэн харав. Энэ бол Умбора гаднаас орж ирээд ярианд оролцож байгаа хэрэг байв.

- Энэ чинь юу гэсэн үг вэ? Чи яагаад ингэж ярьж байгаа юм бэ? гэж Инфодоос асуув.

- Аан гэж бай, Инфодоос. Би чамд нэгэн түүх ярьж өгье. Имотигийн эхнэр эндээс Игноси хүүгээ аван зугтаж явсан. Уулыг даван, цөлийг гаталсан ч тэд үхээгүй. Тэд азаар нэгэн омгийнхонтой нийлсэн юм гэж Умбора хэллээ.

- Хэн чамд наад түүхийг чинь ярьж өгөө вэ?

- Сонсож байгтун, одоохон хэлж өгөмз. Тэд явсаар байгаад Зулу хүмүүсийн амьдардаг газар очсон. Тэд тэндээ он удаан жил амьдарчээ. Эцэс дор эх нь үхэж, Игноси хүү тэнүүлчин болов. Тэр эхийнхээ ярьж өгдөг байсан улс орноо, аавынхаа аллагын тухай зүрх сэтгэлдээ тээж явдаг байлаа. Тэгсээр хэний ч мэдэхгүй газар орны тухай асууж яваа цагаан хүмүүстэй тааралдсан юм. Тэд говь цөлийг гаталж, уулсыг давж явсаар Кукуанагийн газар нутагт ирж чамтай уулзаад байна, Инфодоос гэж Умбора хэллээ.

- Чи чинь галзуураа юу? гэж Инфодоос дуу алдав.

- Үгүй дээ, авга ах минь, одоохон харуулья. Би бол Игноси.

Тэрээр гараа ганцхан хөдөлгөөд нөмрөгөө авч шидэн бидний өмнө нүцгэн зогсов.

- Хар даа, Инфодоос, миний бие дээр байгаа шивээсийг сайтар хар гэж залуу Инфодоост хэллээ.

Ингэж хэлээд бие дээрээ байгаа цэнхэр могойг заасан юм. Могойн сүүл ам руугаа орсон харагдана.

Инфодоос үүнийг хараад өвдөг сөхрөн уналаа.

- Тийм ээ, энэ миний алагдсан ахын хүү! Энэ бол жинхэнэ хаан!

Игноси гараа мөрөн дээр нь тавиад,



- Бос бос, ах минь, би одоохондоо хаан биш. Гэхдээ та аавыг минь алсан алуурчныг хаан сэнтийнээс авч хаяхад туслах уу?

- Би чиний төлөө Твалагийн эсрэг тулалдахад бэлэн байна.

- Би хэрэв ялалт байгуулбал та бүхэн манай газар дээр байгаа хамгийн эрхэм зочид болцгооно - гээд Игноси бидэн рүү харав. – Тэгэхээр цагаан хүмүүс ээ, та нар надад туслах уу?

Би хурдхан шиг нөхдөдөө болж байгаа үйл явдлыг ойлгуулав. Тэгээд энэ нутгийн угсаа залгамжлагчид тусална гэдгээ амлалаа. Гэхдээ яаж хаан болох гэж байгааг нь асуусан юм.

- Би энэ талаар хэлж мэдэхгүй. Харин Инфодоост төлөвлөсөн зүйл байж магадгүй гэж Игноси хэллээ.

- Өнөө орой шулмын ан болно. Маш олон хүнийг шулам хэмээн алах болно. Хүмүүс Твалаг үзэн ядаж байгаа нь гарцаагүй. Таны төлөө хорин мянган жадат цэрэг гаргаж чадна. Гэхдээ та тэдэнд хаан гэдгээ батлан харуулах хэрэгтэй. Тэд ямар нэгэн шинж тэмдэг харахаас нааш хөдлөхгүй.

- Тэд тэр тэмдгээ олж үзэх болно оо, Инфодоос. Одоо харин явж, омгийн захирагч, ахлагч нарыг дагуулж ир гэж би хэлэв.

- За эрхэм ээ, гэсээр Инфодоос урцнаас гарлаа. Би энэ зуур Гүүд, Куртис хоёрт хэрэгтэй зүйлсийг хэлэв. Гүүд эм тарианы саваа уудлан жижиг ном, тэмдэглэлийн дэвтрээ гаргаж ирлээ.

- Өнөөдөр 6-р сарын 4. Өнөө орой 8 цаг 15 минутаас сар хиртэнэ. Сарны бүтэн хиртэлт өмнөд Америкт харагдана. Энэ бол чиний тэмдэг, Игноси.

- Бурхан тэнгэр минь, гайхалтай санаа байна! - гэж Куртис хашгираад Гүүдийн нуруун дээр зөөлөн алгадав. – Чи сод ухаантан юм аа.

- Баярлалаа, хөгшин залуу минь. Чиний зөв ч байж магадгүй. Чиний хийх ёстой зүйл гэвэл “Бид өнөө орой сарыг алга хийнэ” гэж тэдэнд хэл.

- Яг цагтаа хиртэх ёстой. Эс тэгвэл бидний хувьд буруугаар эргэнэ шүү дээ гэж би санууллаа.

Тэгээд би Игносид хэлэв.

- Өнөө орой бид сарыг харанхуйд залгиулах болно.

- Найз минь, ямар гайхалтай хэрэг вэ. Үүнд итгэхэд хэцүү ч гэсэн би чиний хоосон үг хэлэх дургүйг мэднэ. Хэрэв өнөө шөнийн хэргийг сайнаар эргүүлж чадвал ачийг чинь ачаар хариулна гэж Игноси хэлэв.

Бид хааны элчийн дуугаар яриагаа тасаллаа. Гурван хүн орж ирлээ. Тэд гартаа нарийн чамин хийцтэй хуяг дуулга, гайхамшигтай сайхан байлдааны сүх барьсан байв.

- Одноос ирсэн цагаан хүмүүс та нарт манай хааны илгээсэн бэлэг! гэж тэд хэллээ.

- Бид хаанд чинь талархаж байна. Одоо харин биднийг орхино уу гэж би хэлэв.

Тэднийг гарсны дараа бид хуяг дуулгыг нарийвчлан үзлээ. Миний харж байсан хуягуудаас хамгийн гайхамшигтай нь тэр байж билээ.

Энэ үед дахин үүдэн дээр чимээ гарч, Инфодоос долоо найман хүн дагуулан орж ирлээ. Игноси дахин тэдний өмнө нүцгэлж, могойн шивээсээ харуулав. Тэгээд бидэнд ярьж өгсөн түүхээ омгийн ахлагч нарт дахин ярьж өглөө.

- Та нар одоо үнэнийг мэдэж байгаа. Аавынхаа хууль ёсны ширээг буцааж авахад нь түүнд туслах уу? гэж Инфодоос хэлэв.

Ахлагч нарын хамгийн ахмад нь болох буурал үстэй дайчин босч ирээд,

- Энэ нутгийнхан Твалагийн эсрэг тэмцэхэд бэлэн байна. Чи үнэхээр жинхэнэ хаан мөн юм бол энэ цагаан хүмүүсээр дамжуулан тэмдэг өг. Тэмдэг өгөхөөс нааш бид хөдлөхгүй гэхэд бусад нь ч гэсэн түүнтэй санал нэг байгаагаа илэрхийллээ.

- Омгийн ахлагч нар аа, хэн нэгэн жирийн хүн сарыг халхлан, өмнүүр нь хөшиг татаж чадах уу?

- Үгүй эзэнтэн минь, тийм юм байхгүй.

- Тэгвэл бид өнөө орой сарны өмнө хөшиг татаж, газар дэлхийг харанхуйд умбуулна. Хэрэв би ингэвэл та нар үүнийг хангалттай нотолгоо хэмээн үзэх үү?

- Тийм ээ, эрхэм ээ. Бид үүнийг хангалттай гэж үзнэ.

Арван нэгдүгээр бүлэг

Шулмын ан

Бид итгэхийн аргагүй байдалд орсон боловч өдрийн үлдсэн хугацааг амарч, төлөвлөгөө боловсруулж өнгөрөөв. Нар жаргахад энд тэндгүй гал асч, дайчид Твала хааны отог руу явж байгааг ажиглаж суув.

Найман цагийн үед бүтэн сар тэнгэрт хөөрч, Инфодоос бидэн рүү ирж явааг харав. Биднийг хаан руу дагаж явах хорин дайчин түүнтэй хамт иржээ. Бид гурав хувцсан дотуураа нөгөөх хуягийг өмссөн байлаа. Хуяг биед их эвтэйхэн, хөнгөхөн байлаа. Бид бас хааны бэлэглэсэн байлдааны сүхийг агсаж, гар буунуудаа зүүлээ.

Хааны их отгийн гадна хорин мянга орчим хүн цугларчээ. Тэд хороо хороогоор эгнэн жагсаж, хоорондоо бага зай гаргасан нь шулмын анчдыг саадгүй нэвтрүүлэх зорилготой аж. Тэнгэрт мандсан сарны туяа, оддын жирвэлзээн дор олон мянган дайчин жад, сүхээ гялалзуулан чив чимээгүй зогсоно.

- Тэд яагаад чив чимээгүй байгаа юм бэ? гэж намайг асуухад Инфодоос:

- Үхэх гэж байгаа хүмүүс чимээ гаргах ёсгүй гэв.

- Хэр олон хүн үхэх бол?

- Их олон хүн үхнэ.

- Бид бас үхэж болох нь ээ?

- Би мэдэхгүй ээ эзэд минь, гэхдээ би та нарын төлөө айж л байна. Бүгдээрээ энэ шөнө амьд гарвал сайнсан.

Биднийг жагсаал дундуур өнгөрч, хэдэн сандал тавьсан нээлттэй талбайд хүрч очиход хааны урцны зүгээс хэдэн хүн ирж явлаа.

- Тэд бол Твала, Скрагга, эмгэн Гагоол болон аллага хийх хүмүүс гэж Инфодоос хэлэв.

Тэд нэг гартаа урт жад, нөгөө гартаа хүнд бороохой барьсан том биетэй дайчид байлаа.

Хаан голын сандал дээр сууж, Гагоол хажууд нь эвхэрч, бусад нь түүний ард зогсов.

- Цагаан эздэд мэнд хүргэе. Сууцгаа. Цагийг хий дэмий өнгөрөөгөөд яахав. Сар хөөрчихлөө, хийх ажилд шөнө богинодно. Эхлээрэй Гагоол, шулмуудыг үнэрлээрэй гэж хаан хэлэхэд өнөөх нь:

- Эхэлье, эхэлье! хэмээн зэвүүн царгиа хоолойгоор бархирав.

Хаан жадаа өргөтөл гэнэт хорин мянган хос хөл зэрэг өргөгдөөд газарт нирхийтэл бууж,

дахин хоёронтаа давтахад газар доргин чичирхийллээ.

Дараа нь жагсаалын тэртээ адгаас нэгэн чихарсан хоолой гарч, “Эмэгтэй хүнээс үй олон эр хүн төрвөл яах вэ?” гэсэн үгтэй хачин дууг удаанаар уянгалуулан дуулахад тэр олон хүн нэгэн зэрэг “Үхнэ” хэмээн нүргэлүүлэв.

Тэр дууг эгнээ эгнээгээрээ залган авахад үг нь мэдэгдэхээ болилоо. Гэнэт бүр холоос нэгэн зүрх зүсэм муухай орилоон хадахад дуу нам гүм болов. Жагсаалын дундуур бидний зүг хачин дүрстэй амьтад гүйлдэн ирж явна. Тэд бол голдуу цагаан үстэй хөгшин эмэгтэйчүүд байсан бөгөөд нүүрээ цагаан, шараар эрээлэн будсан, нуруу руугаа могойн арьс унжуулсан, бүсэлхийнээсээ хүний ясан хэлхээ зүүсэн, гартаа жижигхэн модон сэрээ барьсан ажээ. Тэд бидний өмнө гүйлдэн ирээд эвхрэн хэвтээ Гагоол руу сэрээгээрээ чичиж:

- Эх минь, бид ирлээ! хэмээн хашгиралдав.

- Сайн сайн, охид минь нүд чинь хурц биз?

- Нүд хурц байна аа, эх минь!

- Чих чинь сонор биз охид минь, цус үнэртэж чадна биз? Хааны эсрэг хор агуулсан шулмуудыг таньж чадна биз?

- Чадна аа, эх минь!

- Тэгвэл охид минь хөдөл, одноос бууж ирсэн цагаан эзэд үзэх гэж яарч байна. Хөдөлж үз охид минь, шулмуудыг үнэртэн гаргаад ир!

Хачин дүрт амьтад эргэж, муухай орилолдон жагсаал дундуур харайж цовхрон оров. Надад хамгийн ойр байсан нэг хөгшин эм дайчдын дундуур хэдхэн алхсанаа зэрлэгээр цовхчиж дэвслэн “Би үнэртлээ, шулмыг оллоо. Хааны тухай муу бодлыг нь сонслоо” гэж орилов.

Тэгээд үнэрч нохой сургууль хийж байгаа юм шиг дороо эргэлдсэнээ нам зогсоод өмнөө зогсож байгаа нэгэн өндөр дайчин руу модон сэрээгээрээ хатгалаа. Тэрхэн хоромд амьгүй юм шиг хөдөлгөөнгүй зогсож байсан нөгөө эгнээний дайчид ухасхийн хөдөлж, нүд ирмэх зуурт өндөр дайчны гараас жадыг нь унагаан барьж аваад хааны өмнө чирч аваачив.

- Ал! гэж Твала, Гагоол, Скрагга гурав хахирган дуугаар бархирав.

Тэр гурвыг үгээ хэлж дуусаагүй байхад нэг дайчин жадаа зүрх рүү нь нэвт сүлбэж, нөгөө нь том бороохойгоор тархийг нь бяц цохив.

- Нэг! гэж Твала тоолоход дайчид цогцсыг чирж зайлуллаа.

Энэ үйлдэл дуусаагүй байхад хоёр дахь дайчин түрүүчийн адил хоромхон зуурт алагдаж Твала:

- Хоёр! гэж тооллоо.

Ийнхүү богинохон хугацаанд хэдэн зуун дайчин амь үрэгдэж, бидний ард уул мэт цогцос овооров. Бид бараг ухаан алдах дөхөж босон харайгаад эсэргүүцэх гэтэл Твала:

- Энэ нохойнууд бол шулмууд учраас үхэх ёстой. Хууль хэрэгжиж байна цагаан хүмүүс минь! гэв.

Бид сандалдаа буцаж суухаас өөр сонголт байсангүй. Шулмын ан арав хагас хүртэл үргэлжлээд завсарлав, Гагоол гэнэт босоод хоёр талдаа саваа мод тулан бидний зүг салгалж байгаа харагдахад Гүүд:

- Намайг дүүжилсэн ч болно, энэ шулам шидээ бидэн дээр туршихыг оролдож байна гэж заналтай хэлэв.

- Чиний зөв, тэр бидний цусанд шунаж байна гэж хэлээд би буугаа шүүрлээ.

Арван хоёрдугаар бүлэг

Охидын бүжиг

Гагоол бидэн рүү дөхөж ирэхэд цус хөрөх шиг болж, арагшаа хартал бүх бие хүйт оргилоо.

Гагоол бидний зүг улам ойртож, бүүдгэр нүд нь сарны гэрэлд гялалзах шиг болов. Тэр бидний өмнө ирж зогсоод саваагаараа зангахад Хенри:

- Хэнийг сонгов? гэж асуутал тэр ухасхийн гүйх шиг болоод Игносийн мөр рүү саваагаараа хатгаж:

- Би үүнийг үнэртлээ. Энэ шулам санаа агуулсан байна. Эхлээд энийг алахгүй бол энэ дайн өдөөнө. Хаантан минь энийг ал! гэж чихарсан муухай хоолойгоороо орилов.

Би босон харайж сандлаа өшиглөв:

- Энэ үхэхгүй, бидний хамгаалалтад байгаа юм шүү, хаантаан.

- Гагоол үүнийг үх гэж сонгосон болохоор үхэх болно, цагаан хүн минь.

- Түүнд халдсан хэнийг ч байсан би ална шүү гэж намайг анхааруулахад,

- Үүнийг барь! гэж Твала тушаав.

Хоёр гүйцэтгэгч над руу ухасхийхэд Гүүд Хенри хоёр ухасхийн босч, Гүүд Гагоол руу онилон Хенри нэг гүйцэтгэгчийг онилов.

Твала ч босч өргөн цээжээрээ миний бууны амыг таглахад гүйцэтгэгчид нь нам зогслоо.

- За одоо яах вэ, Твала? гэж би асуулаа.

- Шидэт саваагаа далд хий. Наад харыг чинь өршөөе. Азтай нохой юм.

- Чи намайг алахаас өмнө би чамайг алж амжина, хаан гуай гэж Игноси тайван өгүүлэв.

- Цагаан хүний нохой чи чанга ярьж байна шүү! гэж Твала уурлав.

- Үнэнийг хэлж байгаа хүн чанга ярьдаг юм. Энэ бол оддын дохио шүү хаан гуай

Твалагийн муухай нүүр татваганаж, ганц нүд нь гялалзсан боловч дуугарсангүй.

- Би аллагаас залхаж байна. Чи бидэнд таатай зүйл амласан. Бид охидын бүжиг үзэхээр ирсэн юм шүү гэж би Твалад хэлэв.

- Зүйтэй, бүжиг эхэл! гэж Твала хэлээд овоолттой цогцосууд руу зааж:

- Энэ нохойнуудыг цөөвөр чононуудад хаяж өг! гэж тушаав.

Тушаалыг тэр дор нь гүйцэтгэлээ. Бид суудалдаа суун хүлээв. Хаа нэгтээгээс хоёр бөмбөрийн дуу зөөлөн дуугарахад толгойдоо цэцгэн эрхи зүүсэн олон охид нээлттэй талбайд бүжиглэсээр гарч ирэв. Охид сарны гэрэлд бүжиглэн ойртоход бөмбөрийн дуу чангарч, хэмнэл нь түргэсч, охид арагш ухран зогсоод тэдний дундаас нэгэн гоо бүсгүй талбайд давшин гарч, ганцаар уран гоё бүжиг үзүүлээд буцаж эгнээндээ оров. Охид нэг нэгээрээ цувран гарч бүжиглэсэн бөгөөд бүгд эхнийхээсээ дутахгүй үзэсгэлэн гоо байв.

Охид бүжиглэж дуусахад хаан гараа өргөлөө. Бөмбөрийн чимээ зогсов.

- Аль бүсгүй хамгийн үзэсгэлэнтэй нь вэ, цагаан хүмүүс ээ? гэж Твала асуув.

- Эхнийх нь гэж би хэлээд тэр бүсгүй рүү заав.

- Үнэхээр сайхан, тиймээс тэр одоо үхэх ёстой!

- Тийм ээ, үхэх ёстой! гэж Гагоол бархирав.

- Яагаад? Тэр охин гоо үзэсгэлэнтэй, сайхан бүжиглэсэн. Үүний төлөө алах гэж үү? хэмээн намайг асуухад Твала бахтай инээж:

- Энэ газарт нэг хууль байдаг юм: хэрэв охидын бүжгийн өдөр хамгийн гоо охиныг хаан дархлахгүй бол тэр охин унах ёстой, урц нь унах ёстой гээд дайчид руугаа эргэж, - Түүнийг авчир! Скрагга жадаа ав! гэж тушаав.

Хоёр дайчин тийш ухасхийхэд охин чанга хашгираад зугтах гэсэн боловч хүчирхэг гар түүнийг шүүрэн авч, орилуулж, тийчлүүлсээр бидний өмнө авчирлаа.

- Нэрийг чинь хэн гэдэг вэ, охин минь? Яасан, хэл чинь татчихаа юу? Хааны хүү хийх ёстойгоо хийх ёстой юу? гэж Гагоол асуув.

Скрагга урагш алхан гарч ирээд, охины дээгүүр жадаа эргүүллээ. Гүүд ямар нэг юм бувтнаад Скрагга руу буугаа онилохыг би хараад:

- Хүлээ! гэж сандран тушаалаа.

- Нэрээ хэл! гэж Гагоол шухитнахад охин:

- Намайг Фоүлэт гэдэг. Би яагаад үхэх ёстой юм бэ? Би буруу юм хийгээгүй гээд уйлагнав.

- Хааны хүү гартаа үхлийг авахаас өөр сайхан зүйл үгүй.

- Үгүй ээ, эх минь, үгүй - гэж охин хашгиран тийчлэхэд Гүүд тийшээ шууд алхлаа.

- Наашаа хар шулам минь, чиний юу гэж хэлснийг би мэдэхгүй, гэхдээ чи энэ охинд хор хүргэхгүй шүү.

Бүх нүд түүн рүү харж байлаа. Охин гялсхийсэн хурдан хөдөлгөөнөөр биеэ суллаж аваад

хөлийн хурдаар зугтав:

- Намайг авраарай! Одноос ирсэн цагаан эцэг минь!

- Айх хэрэггүй ээ, би чамайг хамгаална.

Скрагга урагш алхаж, жадаа өргөтөл Твала хүү рүүгээ ухасхийв.

- Одоо чиний цаг ирлээ, юугаа хүлээсэн юм бэ? гэж Хенри надад шивнэв.

- Сар хиртэхийг хүлээж байна, дохио хараахан ирээгүй байна шүү дээ.

- Аз туршаад үз, энэ залуу, охин хоёрын нэг нь алагдах нь гарцаагүй боллоо.

Би Скрагга, охин хоёрын хооронд орж зогсоод:

- Сонс Твала. Охиныг алж болохгүй, амьд яваг гэв.

- Алж болохгүй гэнэ ээ? Энэ муу цагаан нохой арслангийн өөдөөс хуцах гэнэ. Скрагга, тэрний ал! Хамгаалалтынхан энэ цагаан нохойнуудыг барь! гэж Твала бархирав.

Урцны цаанаас зэвсэгт дайчид бидэн рүү гүйлдэн ирж байна. Миний хажууд манай гурав ирж зогсоод буугаа цэнэглэв. Миний зүрх өсгий рүүгээ орчих шиг болсон ч би “Зогсоцгоо” гэж чанга хашгираад:



- Нэг л алхам ойртвол сарыг унтраана шүү! Бид тэнгэрээс ирсэн гэдгийг мартаагүй биз? Миний үгийг дагахгүй бол ид шидийг минь үзэх болно шүү гэхэд тэд дорoo нам зогсож, Скрагга хүртэл хажууханд ирээд хөшөө мэт зогслоо.

- Тэр юу гэж хуцахыг сонсоо биз? Энэ муу цагаан нохой сарыг дэн унтрааж байгаа юм шиг үлээчих юм гэнэ. Чаддаг юм бол үлээг л дээ. Чадахгүй бол тэр гичийтэй хамт үхнэ гэж Гагоол чихэнд чийртэй хоолойгоороо ёнгинов.

Би сар хартал бид алдаагүй болохыг гэрчилж, төгрөг том сарны нэг тал сүүдэртэж ирснээ дорхноо томорч ирлээ.

Би гараа тэнгэр өөд өргөхөд манай гурав дуурайж байна.

- Сонсоцгоо! Сарны гэрлийг хураагч шидэт үгийг сонсоцгоо! гэж би чанга хашгираад дараа нь дуугаа намсан англиар “унтар унтар” гэж давтан хэлэв.

Сарны туяа миний хэлснээр боллоо. Эргэн тойронд айдсын дуу гарна.

- Болж байна шүү нөхөд минь, намайг дэмжээд өгөөрэй гэлээ.

Хенри Шекспирийн хэдэн мөр чанга уншиж, Гүүд гараа алдлан тэнгэр өөд харж байгаад Британийн сүлд дууллыг дуулав.

Бидний “ид шид” үр дүнгээ өгч, сар улам бүдгэрэв. Эргэн тойронд сандран хашгирах, энгэнэн уйлах дуу улам ихсэж, энд тэндгүй газар өнхрөн унаж харагдав.

- Харав уу, Твала! Хараач, Гагоол! Бид хоосон үг хэлж байна уу? хэмээн цээж рүүгээ зангалаа би.

Дараа нь дайчдад хандаж:

- Та нар тэмдэг харья гэсэн байх аа. Тэмдгийг чинь харуулаа. Өө сар аа, улам харанхуйлаад өг! гэж хашгирахад сар миний хэлснээр болов.

Манай хоёр шүлгээ уншиж, сүлд дуугаа дуулж, кукуанасчууд энд тэндгүй өнхрөлдөнө.



- Сар үхчихлээ, бид харанхуйд умбалаа! гэж Скрагга ориллоо.

Тэгээд Хенри рүү жадаа шидтэл жад нь түүний өмссөн хуягаас ойн унахад Хенри жадыг нь буцааж шидэн нэвт жадлав. Скрагга үхэдхийн уналаа. Тэгмэгц олон үймэлдэн замбараагаа алдаж, дайчид тал тал тийшээ зугтаж, бүжигчин бүсгүйчүүд хаалга руу бөөнөөрөө гүйлдлээ. Хаан урц руугаа зугтаахад эмгэн болон дагуулууд араас нь дагалаа. Хэдхэн мөчийн дараа бид гурав Инфadoo, Фоүлат болон бидэнтэй тохиролцсон захирагчид талбайд үлдлээ.

- Захирагч нар аа, та нарт бид тэмдэг үзүүллээ. Одоохон цуглараад тохирсон газар руугаа хурдан гүйцгээ! гэж намайг хэлэхэд Инфadooс урагш гарч ирээд:

- Та нарын хаан чинь энэ байна! гэж зарлаад Игноси руу заав. Игноси захирагч нарыг дуудаж ирүүлээд:

- Миний нүүр рүү харцгаа! Миний нэр Игноси, би бол Имотугийн хүү, та нарын жинхэнэ хаан! гээд байлдааны сүхээ өргөхөд дайчид түүний нэрийг нэгэн зэрэг нижигнэтэл дуудав.

- Явцгаая! гэж Инфодоос хэлээд биднийг дагуулан хаалга руу явлаа. Сар алга болсон тул бид харанхуйд гар гараасаа барилцан алхаж байлаа.

Арвангуравдугаар бүлэг

Тулаанд бэлтгэв

Тас харанхуй байсан боловч дайчид бүх жим, зөргийг мэддэг байсан тул бид богино хугацаанд хангалттай хол явсан байв.

Сар хиртсэнээс хойш нэг цаг гаруй болоод хөмсгөн сар мөнгөлөг өнгөөр гэрэлтсэнээ улаавгар туяа татаж, харанхуйд том дэнлүү асаасан юм шиг гэрэлтүүлэв. Төдөлгүй оддын гэрэл бүдгэрч бид хотоос нэлээд хол явснаа мэдлээ. Одоо бид морины нуруу шиг хэлбэртэй нөгөө ууланд дөхөж ирлээ. Уулын орой тэгш хавтгай учир тэнд дайчид цуглардаг байжээ. Саяны үзэгдлээс айж зугтаасан дайчид аль хэдийн энд ирчихсэн байв.

Бид тэдний хажуугаар өнгөрөхөд манай урцанд орхисон бидний бүх юмыг хоёр дайчин үүрч явааг хараад гайхав.

- Би та нарын юмыг авчруулсан юм. Заримыг нь өөрсдөө авсан байна лээ гээд нэг дайчин руу заахад Гүүд түүн рүү ухасхийж богино өмдөө булааж авав.

- Эзэн минь та гоё цагаан хөлөө далдлах гээ юу? гэж Инфодоос харамсангуй асуухад Гүүд хариу хэлсэнгүй.

Үүр цайхад манай талын хорин мянга орчим дайчид цугларч, Игноси тэдэнд эцэг нь хэрхэн Твалад алагдсан, Игноси ээжтэйгээ хэрхэн зугтаж, алс хол аялсан тухайгаа ярилаа.

- Ийм учраас би жинхэнэ хаан мөн. Миний бие дээр байгаа хааны тэмдгийг захирагч нар чинь та нарт хэлж өгнө. Захирагчид тэмдэг үзүүл гэсэн учраас тэнгэрээс буусан эзэд маань та нарт тэнгэрийн тэмдгийг үзүүлсэн билээ гээд тэр сүхээ өндөр өргөж:

- Та нарын дотор намайг хаан биш гэж хэлэх хүн байвал гарч ирээд надтай тулалд гэв.

Хэн ч тулалдахаар гарч ирсэнгүй, харин мандах нарны туяа түүний сүхэн дээр ойн гялалзав.

- Би жинхэнэ хаан чинь мөн. Хэрэв энэ өдрийн тулаанд бид ялбал миний анхны дайчид та нарт би хүндэтгэлтэй хандаж байх болно. Та нар намайг хаан гэж зөвшөөрөх үү?

- Бид таныг хаанаар өргөмжиллөө! гэж дайчид нэгэн дуугаар хариулав.

- Сайн байна. Одоо Твала өөртөө үлдсэн дайчидтай ирнэ. Тэгэхэд хэн миний дайчин болох нь харагдана. Тулаанд бэлтгэцгээ.

Дайчид тулаанд бэлтгэж байх зуур бид захирагч нарыг дуудан шуурхай зөвлөгөөн хийв. Твала дайчдыг цуглуулахаар хүмүүс илгээнэ. Уулан дээрээс хаашаа ч харсан бүх юм ил учир Твалагийн хүмүүс хаанаас ч ирсэн ил харагдана. Түүнд гучин тав орчим мянган дайчид үлдсэн байх ёстой. Гэхдээ Твала өнөөдөр бидэн рүү дайрахгүй, маргааш л дайрах байх гэж захирагч нар хэлсэн нь үнэн байлаа.

Нар шингэхийн өмнөхөн Лоо хотын зүгээс цөөхөн хүмүүс ирэхэд нэг нь дал модны навч өргөсөн нь нэг ёсны цагаан туг ажээ. Бид гурав Игноси болон зарим захирагчийн хамт уулнаас бууж тэдэнтэй уулзав. Нүдэнд дулаахан, барын арьсан нөмрөгтэй нэгэн дайчин ойртож ирэв:

- Мэнд хүргэе. Хөлөө чирсэн цөөврүүдэд арслангийн мэнд хүргэж ирлээ.

- Ярих юм аа ярь.

- Ганц нүдэт Твалагийн үгийг дамжуулья: Би ухаалаг байж, бага цус урсгахыг хүсч байна. Арван хүний нэг нь үхэж, ес нь үлдэх ёстой. Гэхдээ Скраггаг алсан цагаан Инкубу, түүний боол, миний хаан ширээнд санаархсан хар хүн, миний эсрэг бослого дэгдээсэн Инфодоос нар тамлагдаж үхэх ёстой. Твала ийм өршөөл төгөлдөр үг хэлүүллээ.

Би түүнд хариу хэлэхдээ манай дайчид сонсохоор чанга дуугаар:

- Нохой минь, чи буцаж очоод, энэ уулан дээр цугларсан хүн бүр энэ үгийг хэлүүллээ гэж дамжуул: Бид ялна. Нар хоёр удаа мандахаас өмнө Твалагийн хүүр хаалган дээрээ хэвтэж байх ёстой, Твала эцгийг нь алсан Игноси хаан болох ёстой. Одоо хурдан буц нохой минь.

Элч инээж:

- Маргааш ямар байхыг чинь харна аа, сарыг харанхуйд оруулсан цагаан нохойнууд аа. Маргааш уулзацгаая, намайг хүлээж байгаарай, би ч гэсэн залбирья.

Тэднийг явмагц нар жаргав.

Бидэнд хийгээд байх ажил байсангүй, жаахан идэж ууж аваад унтацгаав.

Үүрээр Инфодоос биднийг сэрээж, Твалагийн хүмүүс манай харуулууд руу ойртож байна гэлээ.

Бид тулааны хувцсаа өмсөв. Хенри өөрийгөө кукуана омгийн дайчин шиг хувцаслалаа. Инфодоос түүнийг хувцсаар хангасан ажээ. Тэр гялгар хуяган дээрээ барын арьсан нөмрөг хөдөрч, хар өд хатгасан дуулга маягийн юм толгойдоо углаад, байлдааны хүнд сүх, цагаан бухын арьсаар бүрсэн төмөр бамбай, шиддэг хуггануудаар зэвсэглээд дээр нь бас гар буугаа зүүхээ мартсангүй. Игноси тэр хоёр зэрэгцээд зогсож байгааг харахад үнэхээр биширмээр. Ийм сүрлэг сайхан хоёр хүн зэрэгцээд зогсч байхыг анх удаа л үзэж байгаа минь энэ.

Бид яаран хооллоод юу болж байгааг харахаар хөдлөв. Чулуугаар босгосон бэхлэлт дотроо Инфодоос өөрийнхөө хороотой нөөц хүч болж үлджээ. Дайчид газар элэглэн хэвтээд Твалагийн арми хотоосоо урт урт цуваагаар шоргоолж мэт наашилж байгааг ажиглаж байна. Тус бүр арван нэгээс арван хоёр мянган хүнтэй гурван цуваа байлаа.

Удалгүй нэг нь бидний баруун талаар, нөгөө нь зүүн талаар, гурав дахь нь биднийг шууд чиглэн алгуур ойртов.

- Бидэн рүү гурван талаас довтлох гэж байна гэж Инфодоос хэлэв.

Үнэхээр ч таван зуу орчим ярд дөхөж ирээд гурав дахь цуваа зогсож, нөгөө хоёрыгоо байраа эзлэхийг нь хүлээлээ.

- Пулёмет байсан ч болоосой, тэгвэл би энэ тэгш өндөрлөгийг хорин минутад цэвэрлэх байлаа гэж Гүүд халаглав.

- Бидэнд пулёмет байхгүй. Гэхдээ Куатермэйн чи нэг буудах гээд үз. Чам руу захирагч бололтой нэг өндөр этгээд ойртож яваа биз дээ. Түүнийг чи алдаж буудахгүй гэсэн магадлал нэгийн эсрэг хоёр байна гэж Куртис хэлэв.

Миний шар гозойж, буугаа цэнэглээд, чулуун дээр хөдлөхөөргүй байрлуулаад хүлээлээ. Миний бай манай байрлалыг сайн харах гэсэн бололтой цэргүүдээсээ арван ярд түрүүлж айсуй. Би гохоо дарсан боловч алдаж, бай маань зүүн тийшээ гурав том харайгаад газар унав.

- Сайн байна Куатермэйн, чи түүнийг айлгаж чадлаа гэж Гүүд улам шар малтав.

Хүмүүсийн нүдний өмнө алдаж буудсандаа уур хүрч, түргэн зуурт онилоод дахин буудлаа. Хөөрхий бай маань зэвсгээ дээш шидээд нүүрээрээ газар шааж уналаа.

Манайхан уухайлан хашгиралдаж, Твалагийнхан айж, газар хэвтэцгээв. Хенри, Гүүд хоёр ч гал нээж, би дахин хоёр сум тавьсан бөгөөд дайсан бууны тусгалд орж ирээгүй байхад бид арваад хүнийг жагсаалаас гаргалаа. Бид буудахаа зогсоход манай зүүн баруун талаас уухайлан хашгиралдах дуу чих дөжрөөх шахаж хоёр талаас дайсан дайрлаа.

Арвандөрөвдүгээр бүлэг

Довтолгоо эхлэв

Дайсан дохио авмагцаа уул өөд удаан таран гүйхдээ хоолойн гүнээс нэг дуу дуулцгаах ажээ.

Бидний буу тасралтгүй галлаж, олон хүн үхэдхийн унасан боловч дайснууд түрүүчийн адил дуулж хашгиран, зэвсгээ өргөж, уул өөд шогшсоор л байв. Манай хамгаалалтын тэргүүн шугам уулын тэхий дунд, хоёр дахь шугам түүнээс тавин ярд зайд, гурав дахь нь уулын ирмэг дээр байрласан байлаа. Дайсан “Твала, Твала, Чиле, Чиле” хэмээх байлдааны уриагаа хашгирсаар улам ойртож ирлээ.

Манайхан “Игноси, Игноси, Чиле, Чиле” хэмээн уухайлна. Дайсан хутга шидэх зайд орж ирэхэд хоёр талаас хутга шидэж, уухайлан хашгирах дуу нийлж үргэлжилсэн нижигнээн болов. Зууралдан тулалдаж байгаа хоёр талын дайчид хутгалдаж, нэг цаашаа, нэг наашаа ханарсаар манай тэргүүн шугам ухарч, хоёр дахь шугамтай нийлээд, дараа нь гурав дахь эгнээнийхэн урагш давшин оров.

Дайсны талынхан ядарч туйлдан олон хүнээ алдлаа. Манайхан хоорондоо нийлж, жадаар нягт хориглолт үүсгэсэн тул дайсныг нэвтрүүлсэнгүй. Хенри тулалдааны байдлыг ажиглаж байснаа давшин орж, Генри ч тэссэнгүй дайран орсон боловч би хориглолтын байран дээрээ үлдлээ.

Надтай хамт байсан Игноси тушаал өгч нөөц хүчийг тулалдаанд оруулав. Би тэдэнтэй хамт орохоос өөр арга байсангүй. Миний хийсэн ганц зүйл бол Игносийн том биеийн ард нуугдаж, алах хүнийг нь зааж өгөх маш муу ажил байсныг хүлээх хэрэгтэй. Нэг хоёр минутын дараа би зөвхөн эргэн тойронд хутгалдан алалдаж байгаа хүмүүсийг л ангайн харж байснаас биш юу болж байгааг мэдэх сөхөөгүй болов. Хүмүүсийн аймшигтайгаар хашгиралдах, жад харшилдах чимээг л сонсохоор өөр юу ч хийж чадахгүй байтал гэнэт миний өмнө аймаар том кукуана дайчин толгойноосоо бүлт үсрэх гэж байгаа юм шиг улаан нүдээ эргэлдүүлэн над руу цустай жадаа чиглүүлж байгаа харагдав. Яг тулаад ирэхээр нь би дорогш суутал тэр миний толгой дээгүүр даван унаж, би түүнийг босохоос нь өмнө амжиж буудлаа. Тэгтэл хэн нэгэн намайг дороо хийн унахад би шууд ухаан алдав.

Ухаан ортол би дээш харан хэвтэж, Гүүд дээрээс тонгойн харж байлаа.

- Яаж байна? гэж түүнийг асуухад өндийж биеэ сэгсэрч үзэв.

- Сайн байна, баярлалаа. Тулалдаан дууссан уу?

- Одоохондоо бид тэднийг ухраагаад байна. Гэхдээ бид наад зах нь хоёр мянган хүнээ алдсан. Тэд гурван мянга орчмыг.

Бид хоёр Хенрийг хайж олоход тэр Игноси, Инфодоос болон бусад захирагч нартай байлдааны төлөвлөгөө ярьж байлаа. Одоо ч гэсэн хангалттай их хүчин захирч байгаа Твала биднийг өлсөж үхтэл энэ уулыг бүслэхээр шийдсэн гэж надад дуулгав.

- Маш муу байна гэж намайг хэлэхэд:

- Тийм ээ, ялангуяа усны нөөц дуусаж байхад бүр ч муу гэж Инфодоос хэлээд, - Бидэнд гурван зам байна: эндээ хориглоод өлсөж үхэх, умар зүг рүү бүслэлтийг сэт дайрч гарах, өөрсдийгөө Твалад тушаах. Одноос ирсэн цагаан хүн та алийг нь сонго гэж хэлэх вэ?

Би нөгөө гуравтайгаа хурдан зөвлөлдөөд санаа нэг байсан тул:

- Бид шархаа хүндрэхээс өмнө Твала руу дайрах хэрэгтэй гэж Инфодоост хэлэв.

- Би Твала руу дайрна. Гэхдээ ингэж дайрна гэж Игноси хэлэв, - Энэ уул хагас сар шиг хэлбэртэй, орой нь бидэн рүү чиглэсэн ногоон хэл шиг харагдаж байгаа биз дээ?

- Тийм байна.

- Зүйтэй, одоо үд дунд болж байна, хүмүүс маань тулааны дараа идэж ууж, амарч хүчээ сэлбэх хэрэгтэй. Нар жаргах үеэр авга ах та хороогоо авч ногоон хэл рүү цуварч доошлох хэрэгтэй. Твала хараад та нарыг хүйс тэмтрэхээр цэргээ явуулна. Гэвч хэлний үзүүр нарийхан болохоор Твалагийн хүч бөөнөөрөө та нар руу дайрах зай байхгүй, та нарт нэг нэгээрээ түүлгэнэ. Тантай хамт Инкулу явна. Та нарын тэргүүнд түүний сүх гялалзахыг хараад Твалагийн зүрх үхнэ.

Би хоёр дахь хороог авч араас чинь орно. Тэгэхэд дайсны хүч суларсан байна. Надтай хамт мэргэн Макумулузан явна.

- Мэргэн санаа байна, хаантан минь гэж Инфодоос хэлэв.



- Ингээд Твалагийнхны бүх нүд тулаанд төвлөрсөн байхад дайчдын гуравны нэг нь уулын баруун талаар тойрч, Твалагийн хүчний зүүн талаас дайрна, дахиад гуравны нэг нь уулын зүүн талаар тойрч, Твалагийн баруун талаас дайрна. Ингээд баруун зүүн хоёр эвэр Твалаг тосч авна. Миний цагаан эцэг Боугван баруун эвэртэй хамт яв, таны шилэн нүд дайчдад зориг нэмнэ.

Байлдааны төлөвлөгөөг захирагч нарт танилцуулсны дараа арван найман мянга орчим хүнтэй арми маань тулалдаанд бэлэн болов.

Арвантавдугаар бүлэг

Саарлуудын сүүлчийн тулаан

Армийн хоёр жигүүр Твалагийн тагнуулчдын хурц нүднээс нуугдан сэмхэн хөдөлсний дараа бид гучин минут хүлээв.

Би хар дуулгат дайчдын нарийхан цуваа уулын ирмэг даган могой мэт мушгирахыг ажиглаж байлаа. Цаг орчим хугацаа өнгөрсний дараа тэд үхлийн тулаанд орно.

Дараа нь Игноси бухнуудын хороог авч хөдлөв.

Бид налуу оройн ирмэгт хүрээд саарлууд замынхаа хагасыг туулсан эсэхийг харав. Твалагийн хуаран хөл хөдөлгөөн ихтэй, хороод тогтмол зайтайгаар тулааны талбар руу гарч байлаа. Саарлууд уулын хажуу руу буугаад зогсчээ. Бид саарлуудын ард зуу орчим бээрийн зайтай байрлав.

Твалагийн их хүч бидний зүг шууд наашилсан боловч хавцлаар бөөнөөрөө гарч багтахгүйг үзээд хөдөлгөөн нь удааширлаа. Тэдний өөдөөс саарлуудын жад шивээлэн угтсан тул Твала эхний хороогоо шууд саарлууд руу дайр гэж тушаав. Саарлууд тэднийг тавин ярд ойртуулж байгаад бүрэн хүчээрээ дайралтад орлоо. Дайсан олон хүнээ алдаж, хүчээ дахин эмхэлсэн бөгөөд саарлууд одоо дайсны хоёр эгнээтэй шууд тулгарч, гуравны нэгээ алдлаа.

Саарлууд дайсны дайралтыг зогсоогоод дараачийн дайралтыг нь хүлээв. Хенрийн шар толгой саарлуудын дунд нааш цааш сүлжин байгааг хараад одоо хүртэл амьд байгаад нь баярлав.

Бид тулалдааны талбарт хүрэхэд дөрвөн мянган хүн хэвтэж, газар цусанд будагдсан байв. Гэвч одоо үлдсэн хоёр мянган саарлуудад цагаан дуулгатай хоёр дахь хорооны дөрвөн мянган дайчин хүч нэмэгдүүлэхээр ирээд байна. Энэ удаагийн тулалдаан түрүүчийнхээс ширүүн, удаан болж, дайны аймшигт үзэгдэл нүд халтирааж, дуу чимээ нь чих дүлийрүүлж байлаа. Хенрийн дуу тэр чимээн дундаас ялгарч, сүх нь дуулгануудын дээгүүр гялалзан харагдсаар.

Эцэст нь дайсан хэдэн зуун хүнээ тулалдааны талбарт орхиод зугтлаа.

Миний санаж байгаа юм гэвэл гэнэт хажуу талаас газар доргиосон зэрлэг хашгираан сонсдож, бидний өмнө зууралдан тулалдаж байсан хоёр талын байрлал гэнэт өөрчлөгдөн, чих дөжрөөж байсан хашгиралдаан, олон жадны галзуу хавиралдаан, цусан улаан манан дундах зүүд мэт тулалдааны үзэгдлүүд хаа нэг тийшээ дайжиж байлаа. Нэг мэдэхэд би уулын ар ирмэг дээр байсан саарлуудын хорооныхны дунд орчихсон, яг Хенригийн архан талд ирчихсэн байв. Яаж яваад ирчихсэн юм бүү мэд.

Гэвч байлдаан үргэлжилсээр байсан юм шүү. Өвгөн захирагч Инфодоос дайчдадаа тушаал өгч, тэднийгээ зоригжуулахын тулд хаяа хошин үг чулуудах зуур арслан бар мэт үсчин тулалдаж байлаа. Гэхдээ л хамгаас сүрлэг нь ноён Хенри байсан бөгөөд дуулга нь хаа нэгтгээ гээгдэж, урт гар үс нь туг шиг дэрвэн, гар, сүх, хуяг нь нэлдээ улаан болж, урдаас нь сөрөх тулсан улаан голтон нэг ч байхгүй болсон харагдана.

Гэнэт “Твала, Твала” гэсэн хашгираан тулааны чимээг намжаах мэт цуурайлахад байлдааны сүх, бамбайгаар зэвсэглэсэн аварга биет, ганц нүдэт хаан тулалдааны дундуур хага яран орж ирэв.

- Инкубу, миний хүүг хөнөөсөн цагаан нохой чи хүрээд ир! Чаддаг юм бол чи намайг алаад орхиё! гэж хашгираад тэр Хенри рүү хутга шидэхэд Хенри бамбайгаараа хааж амжив.

Твала түүн рүү дүүлэн очиж, том алман сүхээрээ бамбай руу нь аймшигт хүчээр буулгахад Хенри газар өвдөглөн суун туслаа.

Гэнэт баруун, зүүн талаас манай нөөц хүчний дайчид довтлон ирэхэд тулалдааны хувь заяа тавхан минутад шийдэгдэв. Твалагийнхан байлдааны талбарыг орхин, Лоо хотын наадах өндөрлөг газар таран зугтаж буй цэргүүдээр дүүрэх нь тэр. Дөнгөж саяхан биднийг бүслэн шахаж байсан их хүч хийсэх мэт алга болж, бид уулан дээр далайн давалгааг буцаан шидэгч хадан цохио мэт зогсож үлдлээ. Эргэн тойронд алагдсан дайчид хөглөрнө. Саарлуудаас ердөө ерэн таван дайчин үлдсэн байна.

Гартаа шархадсан Инфодоос тулалдааны талбарт босч ирэхгүй хэвтэх дайчдаа харан уйлж:

- Баатрууд минь, энэ өдрийн тулалдааныг үеэс үед ам дамжуулан ярих болно гээд Хенри рүү эргэж, - Инкубу чи үнэхээр агуу баатар юм аа, би дайчдын дунд олон он жилийг өнгөрөөхдөө чам шиг гарамгайг нь үзээгүй гэж магтав.

Буффало хорооноос амьд үлдсэн саарлууд Лоо руу давшиж байлаа. Игноси биднийг араасаа ир гэж дуудуулжээ. Бид шууд хөдлөв. Тэрбээр өнөөдөр байлдааныг бүрэн ялалтаар дуусгаж, Твалаг олзлохоор шийджээ. Замд, биднээс зуугаад алхмын цаана нэг шоргоолжны үүрэн дээр Гүүд сууж байв. Дэргэд нь нэг кукуана дайчин хэвтэж байлаа.

- Гүүд шархадсан бололтой гэж Хенри сандарлаа.

Тэр үгээ хэлж дуусаагүй байхад үхсэн кукуана дайчин гэнэт үсрэн босч, Гүүдийн толгой дээгүүр жадаа эргүүллээ.

Арванзургаадугаар бүлэг

Твалагийн төгсгөл

Бид тийшээ гүйв. Нөгөө дайчин Гүүдийг хэд хэд жадалж амжлаа. Тэгээд биднийг харангуугаа зугтаж одов. Гүүдийн хөдөлгөөнгүй хэвтэж байгааг хараад би үхчихэж гэж бодов. Гэтэл мань хүн цонхигор царайдаа инээмсэглэл тодруулан өөдөөс харж байдаг байгаа. Нүдний шил нь ч байдаг газраа байж л байна.

- Энэ хуяг ч бөх зэвсэг юм аа. Хөөрхий тэр кукуанаг би бараг л хуурчихлаа гэж хэлээд тэр ухаан алдав.

Түргэн зуурт шалгаж үзэхэд хөлдөө хутганы хүнд шархтай байв. Шидсэн хутга хөлд нь зоогдсоныг тэр сугалжээ. Цус их алдсан байна. Бат хуяг түүний зөөлөн биеийг жадны үзүүрээс найдвартай хамгаалжээ. Түүнийг бамбай дээр хэвтүүлэн авч явлаа.

Хотын хаалганд тулж ирэхэд Твалагийн тушаалаар хоёр эгнээ харуул зогссон байв. Харуулын захирагч нь арми хот дотор байгаа гэж мэдээлэв. Игноси элч явуулж, бүх цэрэг жагсаад, зэвсгээ газар тавь гэж тушаав.

Бид хот руу орлоо. Твалагийн арми замын хоёр талаар эгнэж, жад, бамбайгаа газарт тавиад, толгой гудайн зогсоно. Хажуугаар нь өнгөрөхөд дайчид Игносид хааны ёсоор хүндэтгэл үзүүлэв. Бид шууд Твалагийн отог руу очлоо. Түүний урцын өмнөх том талбай хов хоосон, ердөө Твала л сандал дээр суух агаад байлдааны сүх, бамбайгаа хажуудаа тавьсан харагдана. Цаана нь Гагоол цагариглан хэвтэх аж. Биднийг дөхөж очиход Твала дуулгатай толгойгоо өргөж, ганц нүдээрээ Игноси өөд өлийн:

- Хаантны алдар бадартугай, надад ямар хувь бэлтгэв дээ? гэв.

- Миний эцэгт таны өгсөн хувийг л өгнө дөө. Эцгийн минь хаан ширээг та олон жил эзэгнэлээ.

- Би үхэхэд бэлэн байна аа, гэвч би Кукуанагийн хаан тулаанд үхдэг ёсыг дээдэлнэ.

- Тэр хүслийг чинь биелүүлье. Хэнтэй тулалдахаа сонго. Миний хувьд би чамтай тулалдахгүй. Хаан дайнаас өөр шалтгаанаар тулалдах ёсгүй.

Твалагийн ганц нүд бидэн рүү чиглэснээ Хенри дээр тогтов.

- Инкубу! Өнөөдөр эхэлсэн тоглоомоо дуссгачих уу хоёулаа, эсвэл би чамайг хулчгар гэж тооцох уу?

- Үгүй ээ, өнөөдөр чи Инкубугай тулалдахгүй гэж Игноси бат нот хэлэхэд,

- Хэрэв тэр айж байгаа бол би түүнтэй тулалдахгүй гэж Твала хэллээ.

Хенри тэр хоёрын яриаг ойлгоод, нүүр нь улайж:

- Би тулалдана аа, би айгаагүй гэдгийг тэр мэдэж аваг гэлээ.

- Дэний юманд амиараа дэнчин тавих хэрэггүй. Өнөөдөр чамайг тулалдаж байхыг харсан хэн ч чамайг хулчгар гэж хэлэхгүй гэж би хажуунаас нь ярианд оролцлоо.

- Би тэрэнтэй тулалдана, одоо ч тулалдахад бэлэн байна гээд Хенри урагш алхаж сүхээ өргөв.

- Хэрэггүй ээ, цагаан ах минь, өнөөдөр чи хангалттай тулалдсан гэж Игноси хориглолоо.

- Тулалдана гэж Хенри хариулав.

Твала тачигнатал инээгээд босч, Хенригийн өөдөөс тулан зогслоо. Шингэх нар тэр хоёрын аварга биеийг гийгүүлж, аль алинаас нь гал бадарч байгаа юм шиг харагдуулна. Тэр хоёр үнэхээр эн тэнцүүхэн өрсөлдөгчид ажээ. Тэр хоёр сүхээ өргөн, бие биеэ сонжин тойрч байлаа. Хенри гэнэт ухасхийн Твала дээр хүнд цохилт буулгахад Твала бултан зайлж, Хенри эрчиндээ хариугүй унах дөхөв. Твала сүхээ толгой дээгүүрээ нэгэнтээ эргүүлээд асар их хүчээр буулгалаа. Миний зүрх амаараа гарах дөхсөн тэр агшинд Хенри зүүн гарын огцом хөдөлгөөнөөр бамбайгаа сүхний өөдөөс тосов. Сүх бамбайнаас нь халтирч зүүн мөрөн дээр нь буусан боловч хуяг нь хамгаалсан тул гэмтсэнгүй. Хенри Твалагийн бамбай дээр сүхээ дахин буулгав. Тэгээд тулалдагч хоёр ээлж дараалан аймшигт хүчтэй цохилт бие биен дээрээ буулгахад аль аль нь бамбайгаараа хаах юм уу, бултан зайлж байв. Тойрон зогссон дайчид тэдний довтолгоо бүрийг уухайлан дэмжиж байлаа.

Хенри бас нэг аймшигт цохилтыг бамбайгаараа хаах тэр агшинд хамаг хүчээ шавхаж зөрүүлэн цавчтал Твалагийн бамбай хага үсэрч сүх мөрөн дээр нь буусан боловч хуяг нь хамгаалжээ. Твала хариу цавчихад сүх Хенригийн сүхний ишин дээр булаа.

Хенригийн сүхний толгой ханхийн үсэрч, газарт зоогдов. Твала уухайлан дайрахад би нүдээ анихаас өөр юм хийж чадсангүй. Нүдээ нээхэд Хенригийн бамбай газарт хэвтэж байна. Хенри хүчирхэг том гараараа Твалагийн бүсэлхийгээр тас тэвэрсэн байв. Тэгээд хоёулаа газарт унаж, дээр доороо орон өнхөрч гарлаа. Твала Хенригийн шанаа руу сүхээ буулгаж, Хенри бүснээсээ хутгаа сугалан Твалагийн хуягийг нэвт шаав.

- Сүхийг нь ав! гэж Гүүд жингэнэтэл хашгирч байна.

Тэрхэн хоромд Хенри хутгаа хаяад Твалагийн бахим гарт тас атгагдсан сүхийг нь авахаар зууралдав. Тэр хоёр догшин барс мэт дээр доороо орон тэмцэлдэж байтал Твалагийн бугуйг ороосон бухын ширэн бугуйвч тас үсэрч, Хенри сүүлчийн хүчээ шавхан Твалагийн гараас мултрахад гарт нь сүхний бариул атгаастай байлаа.

Дараачийн хоромд Хенри хөл дээрээ босоход нүүрнийх нь шархнаас цус урсаж байв. Твала ч бослоо. Тэр бүснээсээ хутгаа сугалаад Хенри рүү дайран яг зүрхэн тушаа нь шаалаа. Маш хүчтэй цохих нь сонсогдсон боловч гайхамшигт хуяг энэ удаа ч гэсэн эзнээ хамгаалжээ. Твала дахин аймшигт хүчээр шаасан ч хуягийг нэвтэлж чадсангүй, харин Хенри гэдэргээ унах дөхөв. Хенри сүхээ эргүүлж хамаг хүчээрээ буулгалаа. Хэдэн мянган хоолой нэгэн зэрэг дуу алдав. Твалагийн толгой биенээсээ тасарч, Игноси өөд өнхрөөд яг хөл дор нь зогсов.

Дараачийн хоромд хүзүүнээс нь цус олгойдсон толгойгүй бие нь эгцрэн зогссоноо газарт пидхийтэл унав. Твалагийн өмсч байсан алтан хуяг газар өнхөрч байна. Хенри шархны өвчин, цус алдалтаа даалгүй түсхийтэл унав. Түүний тэр дор нь босгож, нүүр рүү нь хүйтэн ус цацав. Хенри нүдээ нээлээ. Тэр амьд байна!

Нар жаргаж, би тоосон дунд хэвтэж байгаа Твалагийн толгой руу очиж, углаастай байгаа очир эрдэнийн титмийг авч Игносид өгөв:

- Үүнийг ав, Кукуанагийн хууль ёсны хаан минь!

Тэр титмийг толгойдоо өмсөөд дайчид руугаа эргэж:

- Баярлацгаа, миний ард түмэн! Дарангуйлагчийг дарлаа, та нарын хаан би байна!

Твалагийн элчид миний хэлсэн үг үнэн болж, дөчин найман цагийн дотор Твалагийн толгойгүй бие хааны урцын хаалганы дэргэд хэвтэж байлаа.

Арваннаймдугаар бүлэг

Цагаан хүн

Гурав хоногийн дараа нар жаргаж байх үеэр бид “Гурван шулам” хэмээх гурвал уулын бэлд буудаллав. Бидэнтэй Инфодоос, Фоулат, Гагоол нар болон цөөн тооны хамгаалагчид хамт явлаа.

Маргааш нь бид гурван зуун жилийн өмнө Хосе де Силвестрагийн амь насаа зориулсан тэр итгэхийн аргагүй их баялаг эрдэнэсийн ууланд хүрлээ. Бид олж чаддаг болов уу, яадаг бол?

Бидний өмнө агуу Соломоны их зам голын оргил хүртэл зурайж байна. Оргил биднээс таван бээр орчим зайтай байлаа.

Ерээд минут болоод асар том дугариг нүхэнд тулав. Нүхний хана нь налуу бөгөөд гурван зуун фут орчим гүн, хагас бээр өргөн байлаа.

- Та энэ юу болохыг мэдэх үү? гэж Гүүд, Хенри хоёр асуугаад нүх рүү тонгойн харснаа үг дуугүй толгой сэгсрэв.

- Өө, та нар Кимберлийн эрдэнийн уурхайг хэзээ ч хараагүй юм байна л даа. Энэ бол Соломоны уурхай. Тэр цэнхэр судал болон цохионы ойролцоох урсгалыг харж байна уу? тэр бол эрдэнэ угаадаг газар. Та нар намайг голланд хүн хэмээн нэрлэж болно гэдэгт би итгэлтэй байна гэж би хэлэв.

Тэр том нүхний дэргэд хүрээд зам хоёр салаалж, нүхийг хоёр талаар нь тойрчээ. Бид замаар явж, урдхан талд гурван цамхаг мэт өндөр багана байхыг харав. Тэдгээр нь кукуана хүмүүсийн “Чимээгүй хад” гэж нэрлэдэг аварга том чулуун сийлбэрүүд ажээ.

Бүгд хорин фут орчим өндөр ажээ. Дундах нь эмэгтэй хүний толгойтой, хоёр нь эрэгтэй хүний толгойтой аж. Гурвуулаа ер бусын уран сийлбэртэй юм.

Инфодоос бидний дэргэд зогсоод, “Чимээгүй хад”-нд дуугүй мэхийн ёслов. Бид бунхан руу шууд орох уу, үдийн хоол хүртэл хүлээх үү гэж түүнээс асуулаа. Гагоол биднийг шууд дагуулж орё гэж хэлэв. Бид бага зэрэг хүнс аваад орё гэлээ.

Фоулат билтон хэмээх борцолсон мах, хоёр сав ус бэлтгэж өгөв. Бидний өмнө найман фут гаруй өндөр хадан хана тулав. Тэр хана биднээс дээш гурван мянган фут өндөр оргил хүртэл үргэлжилжээ. Гагоол бидэнд шулмын адис өгөөд таяг тулан биднийг замчлав. Бид араас нь дагаж явсаар уурхайн ам боллолтой нарийхан нуман хаалганд хүрэв.

- За одноос буусан цагаан хүмүүс минь, үзэх юмнаасаа айж үхэхгүйн тулд зүрхээ чангалаарай гээд Гагоол хормой дороосоо дүүрэн тостой сав гаргаж, бамбар асаав.

Тэгээд харанхуй нүх рүү орлоо. Бид түүний араас багагүй айдас тээн орж, Фоулат Гүүглийн гараас чанга барьж явав.

- Нүүр рүү нэг юм цохичихлоо гэж Гүүдийг хэлэхэд:

- Дуугүй л яваад бай гэж би захирав.

Тавин алхам яваад гэрэл ихэслээ. Дахиад нэг минут болоход бид амьд хүний нүд бүлтэрмээр ер бусын гайхамшигтай сайхан үзэгдэлтэй тулгарав.

Энэ бол дээврээсээ бүдэгхэн гэрэлтэй томхон сүмийн дайтай агуй байлаа.

Агуйн хана нь мөс мэт харагдавч үнэндээ нүсэр том сталагмит ажээ. Зарим нь дээвэрт тулсан өндөр, зарим нь хорин фут орчим өндөр байв. Гэвч Гагоол бидэнд алмайран зогсох зав өгсөнгүй, биднийг дуудан доошлов. Тэр нам гүм агуйн нөгөө талд байгаа нүх рүү очоод:

- Та нарт бунхан руу орох хангалттай зориг байна уу? гэж тэр үл мэдэг тохуурхсан шинжтэй асуугаад, тап тапхийтэл алхсаар уруудлаа.

Бид араас нь дагасан юм. Хориод алхам яваад дөчөөд фут урт, гучаад фут өргөн харанхуй агуйд оров. Хамгийн түрүүнд нүдэнд туссан зүйл нь том чулуун ширээн дээр том цагаан юм, түүнийг тойрон жижиг цагаан юмс байна. Дараа нь ширээний төвд том бараан юм, тэгээд өөр үй олон юмнууд байгааг бамбарын гэрэлд харав.

Би тэдгээрийг хармагц ухасхийн эргэлээ, хэрэв Хенри барьж аваагүй бол тэндээс гарч зугтаах байлаа.

Урт чулуун ширээний цаад талд ясан гартаа урт жад барьсан, арван таван фут орчим өндөр хүний араг ясан дүртэй Үхэл өөрөө сууж байв. Тэр жадаараа хатгахад бэлэн толгой дээрээ өргөсөн байх агаад нөгөө ясан гараа ширээн дээр тавьжээ. Тэр урагш бөхийн суусан учир эрүү нь баг зэрэг ангайж, юм хэлэх гэж байгаа юм шиг харагдана.

- Агуу тэнгэрс минь, энэ юу вэ? гэж би асуулаа.

- Тэд нар бас юу вэ? гэж Гүүд эргэн тойронд нь байгаа цагаан юмс руу заав.

- Энэ юу вэ? гэж Хенри ширээний голд байгаа бараан юм руу заав.

- Хи- хи- хи, - хэмээн Гагоол инээж, -Үхлийн танхимд орж ирсэн хүмүүст зориулсан юмнууд. Хи- хи- хи. Инкубу, нааш ир. Чи нааш нь илгээсэн хүмүүсээ хар гээд Гагоол Хенрийн хувцаснаас арьс яс болсон гараараа чангаан, ширээ рүү очиход бид дагалаа.

Тэгээд ширээнд тулан зогсож, ширээний голд байгаа хар хүрэн юм руу заав. Хенри дуу алдан хашгираад арагшаа цахалсанд гайхах юм байсангүй: Твала чармаа нүцгэнээрээ ширээн дээр толгойгоо өвдөг дээрээ тавин сууж байх нь тэр. Түүний бие дээгүүр нимгэн гялгар хальс тогтож байх юм. Дээвэр дээрээс топ топ дусалж буй усны дуслууд түүний хүзүүн дээр буугаад биеийг нь даган тал тал тийш урсч байгааг би дараагийн хоромд ажиглав. Твала сталагмит болон хувирч байгаа нь энэ ажээ.

Чулуун сандал дээр сууж байгаа цагаан дүрснүүд ч гэсэн сталагмитууд аж. Ийм учраас л

кукуана хүмүүс хаадаа энэ агуйд оршуулдаг юм байна. Олон жилийн туршид тасралтгүй дуслах усан дусал дор цогцсууд мөсжиж, цахиурын шингэнээр хатуурдаг ажээ.

Би тэднийг тоолж үзэв. Хорин долоо байсны сүүлчийнх нь Игносийн эцэг аж.

Арвандолоодугаар бүлэг

Гүүдийн бие базаахгүй байна

Би Хенри, Гүүд хоёртой урц руугаа явлаа. Гүүдийг бамбай дээр өргөж явсан бөгөөд цус их алдсанаас бие нь маш сул байсан юм. Би толгой руугаа цохиулснаас их өвдөж байв. Бидний үйлчлэгч болсон Фоулат бидэнд эмнэлгийн тусламж үзүүлэв. Хенри, Гүүд хоёрын хуягийг тайлахад биеэр нь дүүрэн хөх няц болсон харагдана.

Фоулат нэг ургамлын ногоон навчаар шархан дээр нь бэгнүүр тавилаа. Энэ нь тэдний өвчнийг намжааж, хөнгөн болгосон ч гүн шархыг нь эмчилж арай дөнгөсөнгүй. Гүүдийн “гоё цагаан хөл”-нд хутганы гүн шарх, Хенрийн нүүрэнд сүхний шарх ангайж байв. Гүүд мэс засалчийн мэдлэгээ гаргаж, жижиг хайрцагнаасаа халдварын эсрэг эмээ гаргуулан өөрийнхөө болон Хенрийн шархыг цэвэрлэж, эм цацаж, тос түрхлээ.

Фоулат шөл чанаж, биднийг дайлсанд бид цадталаа идээд унтлаа. Өдрийн үзэгдлүүд нүдэнд эрээлжлээд бараг унтуулсангүй. Дайны талбарт хэвтэж үлдсэн дайчдын эхнэр, хүүхэд, ээж, эгч нарын гашуудлын уйлалдаан дунд яаж ч унтах билээ.

Би хэсэгхэн зуур зүүрмэглэхдээ хар дарлаа. Арайхийн шөнө өнгөрч, намайг сэрэхэд Гүүдийн бие тун хүнд, харин Хенри санаа сэтгэлээр өөдрөг харагдав.

Өглөө Игноси биднийг эргэж ирлээ. Тэр хамгаалагчдаа дагуулан орж ирсэн юм.

- Мэнд хүргэе, хаантан.

- Мэнд хүргэе, хаан нь хаан боловч та гурвын хүчээр л хаан болсон шүү дээ.

Тэр ард түмэндээ өөрийгөө танилцуулахын тулд их найр наадам хийх гэж байгаа тухайгаа ярилаа.

- Гагоолыг яах гэж байна?

- Би түүнийг болон шулам илрүүлэгчдийг бүгдийг нь цаазлах ёстой. Тэр хэзээ залуу байсныг нь хэн ч мэдэхгүй тийм хөгшин, хэзээ ямагт шулам илрүүлэгчдийг сургаж байсан юм.

- Тэр их юм мэднэ дээ.

- Тийм ээ гэж Игноси бодлогошронгүй өгүүлээд, - Тэр гэрэлт чулуунууд хаана байдгийг мэднэ. Та нар энэ талаар мартаж болохгүйг сануулах гэсэн юм. Тэр та нарыг уурхайд хүргээд өгч чадна гэв.

Гэвч тэр өдөр бид хаашаа ч гарсангүй. Гүүдийн бие дөрөв тав хоногтоо ч дээрдэх янзгүй байсан тул бидэнд явах боломж байсангүй. Хенри бид хоёр түүнийг үхэх байх гэж сэтгэлээр ихэд унаж, харин Фоулат Гүүдлийг үхнэ гэдэг бодолтой огтхон ч эвлэрэхгүй байлаа.

- Амьдарна аа! гэж тэр итгэлтэй хэлнэ.

Тэр мэдэж байжээ. Тав дахь шөнө нь тэр Фоулатын гарыг чанга атгаад, чимээтэй нь аргагүй амьсгалан унтаж билээ. Арван найман цаг ийнхүү унтахад нь хөөрхий охин дэргэд нь суусаар л байсан хэрэг.

Зургаа дахь өглөөнөөс эхлэн тэр гайхалтай хурдан сэргэв. Нэг удаа Хенри түүнд:

- Чи ч Фоулатад насаараа өртэй боллоо доо гэж хэлэв.

Гүүд энэ үгийг сонсонгуутаа Фоулата бидний өдрийн хоолыг хийж байсан урц руу намайг дагуулан явж ороод:

- Би чиний ачийг хэзээ ч мартахгүй. Ер нь би чамайг эхнэрээ болгож авлаа гээд хэлээд орхи гэж надад тушаав.

Би охинд Гүүдийн үгийг дамжуулахад тэр охины хар арьс гэрэлтсэн юм шүү гэж тангарагласан ч бэлэн байна.

Охин том хүрэн нүдээрээ Гүүд рүү харснаа над руу эргэж:

- Эзэнтэн минь, мартсан бололтой. Тэр миний амийг аварсан юм чинь, би түүний гарын боол байх ёстой гэлээ.

Түүний амийг аврахад Хенри бид хоёрын гүйцэтгэсэн үүргийг охин мартсан бололтой.

Энэ бол Игноси их зөвлөгөөн хийж, Кукуанасын хаанаар албан ёсоор өргөмжлөгдсөний дараа болсон үйл явдал.

Бид хаанд бараалхаж, одоо Соломоны их замыг тавихад хүргэсэн нууц эрдэнэсийн санг судлахад бэлэн болсноо мэдэгдэв.

- Найзууд минь, би энэ талаар бага сага юм мэдсэн. “Гурван шулам” нэртэй уулсын гүнд энэ орны хаадыг оршуулсан их агуй бий. Бас аль эр үгүй болоод маш олон жил болсон хүний ухсан гүн нүх бий. Бас нэг нууц танхим бий. Тэр бүгдийг Гагоол мэднэ. Олон жилийн өмнө нэг цагаан хүн нэгэн эмэгтэйгээр газарчлуулан харанхуй танхимд орж, тэнд нуусан эрдэнэсийн санг үзсэн тухай домог яриа байдаг. Тэр хүн эрдэнэсийг авч явах гэж байтал эмэгтэй нь урваж, тэр үеийн хаан цагаан хүнийг уул руу буцаасан гэдэг юм.

- Тэр түүх үнэн шүү Игноси, уулнаас бид цагаан хүнийг олсон.

- Тийм ээ, олсон. Хэрэв тэр танхим тэнд байгаа, та нар тэр эрдэнэсийг олбол...

- Чиний толгой дээрх очир эрдэнэ тэнд байгаа гэдгийг баталж байна гээд би хааны толгой дээрх том очир эрдэнийг заав.

- Хэрэв байдаг юм бол та нар даахынхаа хэрээр аваад яв, үүнийг би зөвшөөрч байна. Та нар намайг орхиод явах нь байна шүү дээ, найз нар минь.

- Бид олох ёстой.

- Та нарт ганцхан Гагоол газарчилж чадна.

- Тэр явахгүй болов уу?

- Явахгүй бол үхнэ. Би ийм л зорилгоор түүнийг амьд байлгаж байгаа юм гэж хаан хэлээд Гагоолыг авчир гэж тушаав.

Хоёр минутын дараа түүнийг хоёр харуул авчирлаа.

- Орхиод гар! гэж хаан тушаахад харуулууд гарч одов.

Шулам болсон эмгэн шалан дээрх дэвсгэр дээр атираад бидэн рүү могойнх шиг гялалзсан нүдээрээ нэвт шувт ширтэж байна.

- Сонсч бай хөгшин шулам, чи гэрэлт чулуунууд байдаг танхимыг бидэнд зааж өгөх ёстой гэж Игноси хэлэв.

- Ха-ха, би та нарт хэзээ ч зааж өгөхгүй. Цагаан шулмууд од руугаа хоосон гараа унжуулаад буцах ёстой.

- Би чамаар хэлүүлнэ ээ, эмгэн минь!

- Та нарын бүх ид шид миний дотроос үнэнийг гаргаж чадахгүй.

- Зааж өгөхгүй бол чи үхнэ шүү дээ, Гагоол!

- Үхэх гэнэ үү? Би үхэж чадахгүй, хэн ч намайг алахгүй! гэж шулам хэлэхэд нүдэнд нь айдас гялалзав.

- Би чамайг ална, “шуламсын эх минь” гээд Игноси жадаа шүүрэн толгой дээгүүр нь эргүүлж хэлэв, - Хаан тушаасан бол чи үхнэ!

Игноси жадныхаа хурц үзүүрийг түүн рүү удаанаар ойртуулан нүүрэнд нь хүргэхэд шулам эмгэн зэрлэг муухай хашгираад ухасхийн боссоноо дахин газарт унаад үүд рүү ухран мөлхөв:

- Үгүй ээ, үгүй. Намайг алж болохгүй. Би тэр газрыг зааж өгье. Гэвч танхимд зөвхөн цагаан хүн орж болно. Манай арьстан орвол дээрээс нь үхлийн айдас унана.

- Маргааш чи Инфагоос болон миний цагаан найз нартай тийшээ явж, гэрэлт чулуу байгаа газрыг зааж өгнө. Харин зааж өгөөгүй байвал чи үхнэ. Би чамд хэллээ шүү.

- Би зааж өгнө өө, хэлсэндээ хүрдэг шүү би. Бид хамтдаа сайхан аялна даа. Бид тулалдаанд амь үрэгдсэн хүмүүсийг үзнэ. Тэдний нүд бүлтэрч, тэдний хавирга хэрзийнэ. Ха- ха- ха.

Арванесдүгээр бүлэг

Соломоны эрдэнэсийн танхим

Би тэр аймшигт агуйд байж ханалаа.

- Гагоол, биднийг эрдэнэсийн танхимд хүргэ гэж би зөөлөн дуугаар хэлэхэд тэр:

- Миний эздийг хараад айхгүй байна уу? гэв.

- Явья, биднийг эндээс гарга.

- Тэгье дээ, энэ танхимд миний эзэд байдаг юм. Харин эрдэнэсийн танхим тэр байна. Гэрэл гаргаад та нар орцгоо.

Тэр тосон дэнгээ газар тавиад хажуу тийш зогсов. Би чүдэнз хавиран дэнг асаагаад хананд хаалга хайсан боловч олсонгүй. Гагоол “Энэ замаар яв, эзэд минь” гэв.

- Биднийг мэхэлж болохгүй шүү гэж намайг хатуухан хэлэхэд:

- Би тоглоогүй байна эзэд минь, харахгүй юу гээд тэр хадан хана руу заав.

Би дэнлүүгээр гэрэлтүүлж, нэлээд харсны эцэст шалнаас аажмаар өргөгдөж байгаа том хадыг олж харав. Тэр хад яагаад өргөгдөж байгааг бид мэдсэнгүй. Ердийн тэнцвэрийн зарчим ажилласан байж болох юм. Өөрөөр хэлбэл Гагоол ямар нэг хөшүүрэг дээр дарсан байх. Хад дээш өргөгдөхөд арван фут өндөр, таван фут өргөн нүхний амсар онгойж харагдлаа.

Би сэтгэл хөдөлсөндөө салгалан чичирч байсан юм шүү. Энэ зүгээр л хий үзэгдэл биш байгаа? Хөгшин де Силвестра алдаагүй байгаа? Бид бүх дэлхийн хамгийн баян хүмүүс болох юм уу?

- Одноос бууж ирсэн цагаан хүмүүс минь орцгоо, гэхдээ эхлээд хөгшин Гагоолын үгийг сонсоцгоо. Та нарын хайж байгаа гэрэлт чулуу Чимээгүй нэгний доор байгаа. Тэнд хадгалдаг юм. Хэн анх хадгалсан юм, тэр одоо тэнд байдаг юм уу би мэдэхгүй. Гэвч олон жилийн өмнө нэг цагаан хүн хааны тусламжаар энэ газарт ирсэн юм. Тэр хаан одоо энэ сууж байна гээд ширээн дээр байгаа тав дахь хадыг зааж:

- Тэгээд энэ хаалганы нууцыг мэддэг эмэгтэй хүнээр газарчлуулан энд ирээд, ямааны тулам дүүрэн гэрэлт чулуу хийж авсан. Эндээс гарахдаа нэг том чулуу илүү авсан юм гээд шулам эмгэн чимээгүй болов.

- За тийм байж. Дараа нь де Силвестрад юу тохиолдсон бэ?

- Чи тэр хүний жинхэнэ нэрийг хаанаас мэдсэн юм бэ? гэснээ хариу хүлээлгүй, - Юу болсныг хэн ч мэддэггүй. Гагцхүү тэр хүн эндээс гарахдаа айсан юм уу, яасан юм ямаан тулам дүүрэн чулуугаа орхиод ганцхан том чулуу авсан л гэдэг. Тэр чулуу нь Макумазан чиний Твалагийн толгой дээрээс авсан чулуу шүү дээ.

- Тэр цагаас хойш энд хэн ч орж ирээгүй юу?

- Хэн ч орж ирээгүй ээ, эзэн минь. Одоо л та нар орж ирж байна. Хэрэв би эндүүрээгүй бол тэр ямаан тулам шалан дээр хэвтэж байгаа.

Түүнийг дэнлүү барин хаалга руу явахад Гүүд:

- Гэрлээ наанаа өлгөчих. Хөгшин шулам чиний ярьснаас би айхгүй гээд Фоулатыг хөтлөн хаалгаар ороход бид араас нь дагав.

Фоулат хэдхэн алхаснаа:

- Би орж чадахгүй нь. Намайг энд орхичих гэж гуйв.

Бид түүнийг чулуун дээр суулгаад энд хүлээж бай хэмээн үлдээсэн юм.

Арван тав алхаад бид будагтай модон хаалганд туллаа. Хаалга нээлттэй байсан бөгөөд босгон дээр нь дүүрэн юмтай ямаан тулам тэгнэн хэвтэж байна.

- Би эс хэллүү? гэж Гагоол шивнэв.

Гүүд туламтай юмыг өргөх гэтэл даагдахааргүй хүнд бөгөөд жингэнэн дуугарч байв.

- Ээ бурхан минь, дүүрэн очир эрдэнэтэй юм байна гэж Гүүд шивнэн хэлэхэд Хенри:

- Дуугүй бай. Хөгшин хатагтай, та надад гэрлээ өгчих гэж хэлээд Гагоолын гараас дэнлүүг авч хаалгаар орлоо.

Бид туламтай эрдэнэсийг мартан түүний араас оров.

Ингээд л Соломоны эрдэнэсийн танхимд орчихлоо. Танхим дундуураа хадан ханаар хуваагдсан бөгөөд арван футээс хэтрэхээргүй талбайтай ажээ. Нэг тасалгаанд нь насаараа зараад барахааргүй их зааны соёо байсан бөгөөд нөгөөд нь зэвсгийн авдар шиг том, улаан будагтай хориод авдар байна.

- Энэ л очир эрдэнэ байна даа. Гэрлээ нааш нь гэж би хашгирлаа.

Хенри гэрэл авчрав. Дээд талын авдрын тагийг хэмхэлсэн нь Силвестрагийн хийсэн ажил бололтой. Би гараа шургуулж атга дүүрэн эрдэнэс гаргаж иртэл очир биш, бидний урьд өмнө үзээгүй алтан зооснууд байв.

- Бид ч гар хоосон буцахгүй юм байна даа. Энд арван найман авдар байна, нэг авдарт лав хоёр мянгаас доошгүй алтан зоос бий гэж намайг хэлэхэд,

- Чулуунууд тэр байна, эзэд минь тийшээ хараарай! гэж Гагоол заав.

- Тэр буланд үз, Куртис! гэж би Гагоолын заасан зүг рүү заав.

- Агуу бурхан минь, үүнийг хараач! гэж Хенри хашгирахад бид тийш яарлаа.

Тасалгааны цаад буланд тус бүр нь хоёр фут орчим талбайтай гурван чулуун авдар байв. Хоёр нь чулуун тагтай, гурав дахь авдрын таг хажууд нь тавиастай байлаа.

- Хараач гээд Куртис нээлттэй авдар руу гэрэл тусгатал мөнгөлөг туяа цацруулан гэрэлтэв. Нүд дасаад ирэхийн алдад том том хэмжээтэй, огтлоогүй очир эрдэнэс харагдав. Би заримыг нь авч үзлээ. Үнэхээр мөн байна, ямар ч алдаа мадаг алга.

Би чулуунуудыг самран асгаж:

- Бид энэ дэлхийн хамгийн баян! хүмүүс гэж хашгирав.

- Бид зах зээлийг очир эрдэнээр үерлүүлнэ! гэж Гүүд хэллээ.

- Эхлээд авч харих хэрэгтэй! гэж Хенри хэлэв.

- Хи- хи- хи хэмээн бидний ард Гагоол зэвүүнээр хөхөрнө:

- Та нарын эрээд байсан дуртай чулуу чинь энд хөглөрч байна. Авцгаа авцгаа, гар хуруугаараа тэмтэрч үз, ид, уу, ха- ха- ха.

Очир эрдэнийг иднэ, ууна гэж санахаас өөрийн эрхгүй инээд хүрч би тачигнатал хөхөрч эхлэв. Би өөрийгөө зогсоож чадахгүй инээсээр. Нөгөө хоёр маань ч юу болсныг мэдээгүй мөртөө инээж гарав. Бид гурав учир зүггүй хөхрөлдөж, хажууд сая сая паундын үнэ хүрэх очир эрдэнэ овоолоостой байлаа.

Гэнэт бид инээхээ болив.

- Нөгөө хоёр авдрыг нээгээч, өөрсдийгөө дүүргээч! гэж Гагоол гуаглав.

Бид нэг авдрыг нээхээр ноцолдож байхдаа Гагоол сэм гараад явчихсныг мэдсэнгүй. Гэнэт:

- Боугван! Туслаарай, туслаарай! Наана чинь! хэмээн хашгирах Фоулатын дуу хадлаа.

- Гарцгаая, нөгөө охин... дараа нь...

- Туслаарай, туслаарай! Тэр намайг хутгалчихлаа!

Бид гүйн гартал хадан хаалга алгуур доошлон хаагдаж байлаа. Хажууханд нь Фоулат, Гагоол хоёр тэмцэлдэж байна. Охины цус өвдөг рүүгээ гоожих ажээ. Гагоол могой мэт мурилзан мөлхөж, унаж буй хадан доогуур шургав. Гэвч оройтжээ. Хад түүний дээрээс дарлаа. Гучин тонн тэр хад эмгэн шулмыг доорхи хадтай нь тэгшлэн няц дарлаа. Ийнхүү хадан хаалга бүрмөсөн хаагдах нь тэр.

Хорьдугаар бүлэг

Гарах найдваргүй болов

Бид Фоүлэт руу очлоо. Түүний биед үүссэн хутганы шархнуудыг хараад бид амьдрахгүй нь гэдгийг ойлгов.

- Боугван, би үхэж байна. Гагоолын гарч ирэхийг би хараагүй. Хадан хаалга гэнэт доошилж эхлэхэд би айж, та нарыг дуудсан юм. Тэгээд хаалга руу харж байтал Гагоол гарахаар яарч байгааг нь үзээд барьж авсан юм. Гэтэл тэр намайг хутгалсан. Одоо би үхэж байна, Боугван.

- Өө, хайрт минь! гэж Гүүд хашгираад Фолүлатыг өргөж, өвөр дээрээ тавилаа.

- Макумазан, та энд байна уу? Би юу ч харахгүй байна.

- Би энд байна аа, Фоүлат.

- Та миний өмнөөс Боугванд нэг юм хэлээд өгөөч.

- Хэл хэл, Фоүлат.

- Намайг Боугванд хайртай гээд хэлээд өгөөрэй. Би дахин төрөхөөрөө оддын орноос түүнийгээ эрнэ, олон олтлоо эрээд л байна гэж хэлээрэй. Битгий яваарай Боугван, би гарыг чинь мэдрэхгүй байна, Боугван.

- Явчихлаа шүү дээ! гэж Гүүд хашгираад цурхиран уйлав.

- Санаа бүү зов оо, найз минь гэж Хенри аяархан хэлэв.

- Юу гэсэн үг вэ?

- Чи одоохон түүн дээр очно гэсэн үг. Бид тун удахгүй энд үхнэ гэдгийг чи харахгүй байгаа юм уу?

Хенрийг ингэж хэлэх хүртэл би юу болох гэж байгааг ухаараагүй байснаа сая л ухаарав. Хадан хаалганд няц даруулсан тэр тархи л мэдэж байсан тэр нууцтай хамт бид үүрд булшлагджээ.

Бид Фоүлатийн шарилын дэргэд гашуудан зогсоцгоов. Гагоол бүр эхнээсээ ийм төлөвлөгөөтэй байсан нь илэрхий боллоо. Очир эрдэнэ ууж идэх тухай хэлсэн нь ийм учиртай байж.

- Эндээс бид яавч гарахгүй, дэнлүү удахгүй унтарна. Энэ хадан хаалгыг ажиллуулдаг ямар нэг юм байна уу, эрж олохыг бодъё гэж Хенри сөөнгөтөн хэлэв.

Бид ухасхийн хөдөлж, хадан ханануудыг тэмтрэн эрээд юу ч олсонгүй. Ямар ч татуурга, пүрш, товчлуур олдсонгүй.

- Энэ дотроосоо ажилладаггүй юм байна. Хэрэв тийм байсан бол Гагоол гадагшаа тэгж яарахгүй байсан гэж намайг хэлэхэд:

- Хаалгыг бид яаж ч чадахгүй юм байна. Эрдэнэсийн өрөөнд эргэж орцгооё гээд Хенри аяархан инээв.

Буцаж орох замдаа хөөрхий Фоулатын авч явсан үүргэвчтэй хүнс хананы ёроолд байгааг хараад би түүнийг авлаа. Тэгээд бидний булш болж буй эрдэнэсийн өрөөнд эргэж оров. Дараа нь Фоулатын шарилыг ч орууллаа.

Дараа нь очир эрдэнээр дүүргэсэн гурван авдрыг налан сууцгаав. Тэгээд хоолоо хуваан идэж, ус уулаа.

- За өнөөдөр ч яахав, идэж уулаа. Маргааш үхнэ дээ гэж Хенри хэлэв.

Бид хэсэг дуугүй суулаа. Дэнлүү ч тортогтож эхлэв.

- Куатермэйн, цаг чинь явж байна уу? Хэд болж байгаа бол?

- Зургаан цаг болж байна. Бид агуйд арван нэгд орж ирсэн.

Инфодоос биднийг хүлээж байгаа. Хэрэв бид өнөө шөнө эргэж очихгүй бол биднийг маргааш өглөө хайж эхэлнэ.

- Дэмий л эрэл болно доо. Инфодоос хаалганы нууцыг мэдэхгүй. Хаана байдгийг нь ч мэдэхгүй. Эрдэнэс хайсан олон хүн муугаар төгсөж байсан. Бид тэдний тоог гурваар нэмлээ гэж Хенри хэлэв.

Дэнлүү бүдэгхэн ассаар л.

Хориннэгдүгээр бүлэг

Хонгил

Тэр шөнө их хүнд шөнө байсан юм. Унтах боломжгүй, аниргүй нам гүмийг тэвчих бүр ч бэрх байлаа. Ямар ч дуу чимээ алга. Бид үхэж байна.

Эндээс амьд гарахын тулд эндхийн бүх эрдэнэсийг өгөөд бас жаахан идэх уух юм нэмж авмаар байлаа. Хүн бүх амьдралаа ч золиход бэлэн байдаг эд баялаг, алт эрдэнэс эцсийн эцэст ямар ч үнэгүйг би ухаарав.

Арайхийж өглөө боллоо. Гэвч бидний хувьд шөнө хэвээрээ байсан хэрэг.

Аймшигт нам гүмийг Хенрийн дуу анхлан эвдэв:

- Бид хүчээ сэлбэхийн тулд идэх хэрэгтэй.

- Идлээ гээд дээрдэх юм юу байна? Идэхгүй бол арай хурдан үхэж, энэ аймшгаас сална гэж би хэлэв.

- Амьдрал байгаа цагт найдвар байдаг юм.

Бид идэж уугаад цаг өнгөрч байгааг ухааран суув. Чүдэнз зурж харахад долоон цаг болж байлаа.

Дахин идэж ууж байтал гэнэт надад нэг санаа төрөв:

- Энд агаар байгаа нь ямар учиртай вэ?

- Агуу тэнгэр минь! Би энэ тухай огт бодсонгүй шүү.

Найдварын энэ өчүүхэн оч бидний байдлыг өөрчлөв. Бид эргэн тойрныхоо хана, шалыг алга, өвдгөөрөө тэмтэрч цаг гаруй хайсан ч ан цав байх шинж тэмдэг олсонгүй. Эцэст нь Хенри бид хоёр цөхөрч бууж өгөхдөө тулаад байтал Гүүд:

- Наашаа ир дээ, найзууд аа гэж дуудав.

Бид хоёр тийшээ ухасхийлээ.

- Куатермэйн, миний гар байгаа газар алгаараа дараад үз дээ. Ямар нэг юм мэдрэгдэж байна уу?

- Агаар орж ирж байна.

- Сонс, - гээд тэр хэсэгт дэвстэл хөндий дуу гарлаа.

Би чичирсэн гараараа сүүлчийн гурван чүдэнзнийхээ нэгийг асааж барьтал бид эрдэнэсийн

танхимын алсын буланд байх бөгөөд нүсэр зузаан чулуун шаланд дугариг таглаа шиг хад байхыг олж харав.

Би юу ч хэлсэнгүй. Гүүд халааснаасаа хутгаа гаргаж дугуйг тойруулан хутганыхаа үзүүрээр ухаж эхлэв. Нэлээд ухсаны дараа таг хөдөлж эхэллээ. Дараа нь тэр таглаан дээр зогсоод аяархан дэвсэлж үзэв. Хадны завсраар ан гарав. Гүүд гараа хийгээд татаж үзэхэд огт хөдөлсөнгүй.

- Би оролдоод үзье гээд би хадны ирмэгээс барьж байдаг хүчээрээ татсан ч нэмэр алга.

Дараа нь Хенри оролдоод ч дийлсэнгүй.

- Мэдлээ, мэдлээ Куртис, гэж Гүүд хэлээд торгон алчуур халааснаасаа гарган тагны завсраар оруулан, - Намайг “за” гэж хэлэхээр та хоёр байдаг чадлаараа татаарай гэв.

Бид хоёр хамаг хүчээ шавхан татлаа. Хенрийн аварга нурууны булчин чивчрэн дуугарч байгаа нь надад сонсогдоно. Гэнэт тасхийн ямар нэг юм салах чимээ гараад цэвэр агаар урсан орж ирэв. Дараа нь бид чулуун шалан дээр ар нуруугаараа унав.

- Чүдэнз асаа, Куатермэйн гэж Хенри хэлэхэд бид гурав босч нэг сайн амьсгал авлаа.

- Бурхны алдар мандтугай! Бидний өмнө чулуун шатны эхний гишгүүр харагдлаа.

- Одоо яах вэ?

- Тэнгэрт залбираад шатаар буу!

- Хүлээж бай, Куатермэйн буцаж ороод үлдсэн ус, хүнсээ аваад ир, хэрэг болох юуны магад гэж Хенри хэлэв.

Би эрдэнэсийн танхимаас хоол ундаа аваад гарах гэтэл толгойд нэг бодол зурсхийж, хэзээ ч гарч чадахгүй хаагдсан тэр газраасаа хэдэн очир аваад халаасандаа хийчихье гэж бодлоо. Тэгээд эхний авдар руу гараа дүрж, уранхай цувныхаа халааснуудыг очир эрдэнээр дүүргэв.

- Та нар хэдэн чулуу авахгүй юм уу? Би халааснуудаа дүүргэчихлээ гэж нөхдөдөө дуудав.

- Өө, үгүй, үгүй! Би дахиад хэзээ ч түүнийг хармааргүй байна гэж Хенри хэллээ.

Гүүд хариу хэлсэнгүй. Бодвол өөрийг нь хайрласан хөөрхий охинтой салах ёс хийж байсан биз ээ.

- Хурдал, аажуухан яваарай, би түрүүлж явна гэж эхний гишгүүр дээр аль хэдийн гишгэсэн Хенри хэлэв.

Тэр доошоо буухдаа гишгүүр тоолж, арван тав гээд зогслоо.

- Ёроолд нь хүрлээ. Бурханд талархъя. Энэ хонгил юм шиг байна, бууцгаая.

Гүүд араас нь явж, би сүүлд нь дагав. Би хоёр чүдэнзнийхээ нэгийг асаалаа. Чүдэнзний гэрэлд бид баруун зүүн тийш зөв өнцгөөр салаалсан хоёр нарийхан хонгилын уулзварт байгаагаа мэдлээ. Чүдэнз унтарлаа. Аль зүг рүү нь эргэх вэ? Нэг нь авралын, нөгөө нь сүйрлийн хонгил байж мэдэх билээ. Бид гурав алийг нь ч мэдэхгүй. Гэтэл Гүүд намайг чүдэнз хавирахад харсан байжээ. Чүдэнзний гал зүүн тийшээ татагдаж байсан гэнэ.

- Эсрэг тал руу нь эргэе. Агаар гадагшаа биш, дотогшоо сорогддог гэж тэр хэлэв.

Бид хана дагаж, өмнөх замаа алхам тутамдаа улаараа тэмтрэн урагшлав. Арван тав орчим минут яваад хонгил огцом эргэж, гурав дахь хонгил руу оров. Энэ бол эртний уурхай байна гэсэн санаа төрлөө.

Эцэст нь бид ядарч, заримын маань зүрх өвдөж зогсов. Харанхуй танхимд байсан үхлээс зугтаад харанхуй хонгилд түүнтэй уулзав уу гэж би эргэлзлээ.

Бид хүнснийхээ үлдэгдлийг идэж, үлдсэн усаа уулаа. Ийнхүү зогсож байтал миний чихэнд гадны чимээ сонсогдов. Маш холоос дуулдсан боловч яах аргагүй үргэлжилсэн урт чимээ байлаа.

- Тэнгэрийн минь аврал! Энэ чинь ус урсаж байна шүү дээ гэж Гүүд хэлэв.

Бид тэрхүү хоржигносон чимээг чиглэн алхлаа. Одоо яах аргагүй түргэн урсгалт горхины чимээ гарч байна. Түрүүлж явсан Гүүд усны үнэр авчээ.

- Зөөлөн яваарай, Гүүд. Бид яг хүрээд ирсэн байх шүү гэж Хенри анхааруулав.

Палхийх чимээ гарч Гүүд усанд уналаа.

Бид хоёр түүнийг дуудтал:

- Зүгээр ээ, би хаднаас зуураад авлаа. Гэрэл гарга, хаана байгааг чинь харъя гэв.

Би сүүлчийнхээ чүдэнзийг асаатал яг хөл доор минь гүнзгий ус харлан харагдаж, Гүүд бид хоёроос жаахан зайтай цохионоос зуурсан байв.

- Намайг барьж авахад бэлэн байгаарай. Би сэлээд очно.

Ус цалгиж, хүчлэн сэлэх чимээ гараад минутын дараа Хенри түүнийг уснаас татан гаргав. Түүний ярьснаар бол, газар доорх энэ голоор гарах боломжгүй тул бид өөр зам хайх хэрэгтэй боллоо.

Тэгээд хоол идэж, газар доорх голын сэнхийсэн хүйтэн ус ханатлаа залгилж аваад гарч ирсэн хонгилоороо буцав.

Хонгилуудын уулзварт хүрээд түрүүн орхисон хонгилоор Хенри түрүүлэн явж байснаа:

- Би хий юм хараад байна уу, гэрэл үү? гэж асуув.

Бид нүдээ онийлгон байж хараагаа хүчлэн хартал үнэхээр гэрэл сүүмэлзэж харагдав. Тийш таван минут орчим явсны дараа гэрэл тодров. Хонгил улам нарийссаар үнэгний нүх шиг умгар болсон тул Хенри дөрвөн хөллөж явлаа. Хонгилын хана нь хад биш, шороон хана болсныг үзвэл хадан цохио төгссөн бололтой.

Хенри могой шиг сунасаар арайхийн гарч, араас нь бид хоёр бас л зүдэрч байж гарав. Дээр одод гялалзаж, сэнгэнэсэн салхи үлээж байна.

Бид гурав уулын хажуу руу гулсах газраа гулсаж, алхах газар арай ядан алхсаар зам дээр гарч ирэв.

Замын хажууд зуугаад алхмын цаана түүдэг гал асч, гал тойрон хүмүүс бүртэлзэж байв. Бид тийшээ чиглэлээ. Тэдний нэг нь биднийг үзээд босч ирснээ айсан бололтой газар тэврэн унав.

- Инфодоос! Бид байна аа, найзууд чинь байна.

Инфодоос бидэн рүү гүйж ирснээ нүдээ бүлтийлгэн ширтэж, айсандаа чичирсэн хэвээр байв.

- Эзэд минь дээ, эзэд минь, та нар үнэхээр үхлээс гараад ирлээ гэж үү дээ?

Тэгээд өвгөн дайчин бидний өмнө сөхрөн унаж, Хенрийн өвдгийг үнсэн, баярласандаа хүнгэнэтэл уйлав.

Хориннэгдүгээр бүлэг

Аврагдлаа

Бид хоёр хоног амраад Лоо руу хөдөлж, Игносид болсон бүх явдлыг нэг бүрчлэн ярилаа.

- Одоо бид салах боллоо, Игноси. Бид анх чамайг үйлчлэгчээр авсан, одоо их хаантай салах ёс хийх цаг болж байна гэж намайг хэлэхэд хаан хоёр алгаараа нүүрээ дарав.

- Та зүрхийг минь үгээрээ битгий хоёр хуваа. Та нар явах ёстой. Миний авга ах Инфудоос та нарыг дайчдаараа хамгаалуулан дагаж гарна. Тэр та нарт уулсыг давсан өөр зам зааж өгнө. Сайн сайхныг хүсье, найзууд минь. Үүрд баяртай миний найз, миний эзэн Инкубу, Макумазан, Боугван минь.

Бид хааны өргөөнөөс дуугүй гарлаа.

Маргааш өглөө нь бид Лоо хотыг орхиж явахад Инфудоос Буффалогийн хороотойгоо хамгаалж явлаа. Өглөө эрт байсан боловч хотын хүмүүс гол гудамжиндаа цугларч, биднийг үдэв. Инфудоос бидэнд Кукуана орныг цөлөөс заагласан нуруугаар давдаг нууц зам бий гэж ярьсан юм. Олон жилийн өмнө кукуана анчид өд нь их үнэ хүрдэг тэмээн хяруул агнахаар энэ замаар цөл рүү орсон юмсанж. Тэгээд элсэн цөлд цангаж үхэх гэж байтал тэнгэрийн хаяанд модод харагдахаар нь явж хүртэл сайхан цэнгэг хүйтэн устай том баянбүрд байсан гэнэ. Тэр анчдын зарим нь бидэнтэй явж байсан тул баян бүрдийг амархан оллоо.

Тэндээс бид жинхэнэ анд Инфудоостой салах ёс гүйцэтгэв. Бид бие биедээ сайн сайхныг ерөөж, Инфудоос нулимсаа арай ядан барьж байсан бөгөөд бид ч түүнээс салж явах болсондоо уучлал гуйлаа. Бидний ачааг таван газарчин хувааж үүрээд, бид харих замдаа орж билээ.

Төгсгөлийн үг

Бид танихгүй хүмүүстэй уулзах, танихгүй газар очих, уншаагүй номоо сонгон авахад анхны сэтгэгдэл их чухал нөлөө үзүүлдэг. Тэдгээр сэтгэгдлүүд нь бидэнд халуун дулаан дурсамж үлдээх буюу эсвэл хожим тааралдахад ичиж зовоход хүргэдэг. Сонгодог зохиол анх уншиж эхэлсэн үеийн анхны сэтгэгдлүүдээ санаж чадах уу? Шалгалтад бэлтгээд олон хуудас юм уншин ард нь гарч байсан үеэ санаж байна уу? Эсвэл хүүхэд байхдаа хөнжил дотроо гар чийдэнгийн гэрэлд ном уншиж, Мэйд Марианыг аварч байгаа Робин Хүүдтэй хамт байлцсан уу? “Жаалхан авхай нар” зэрэг зузаан романыг уншиж дуусгахад хэр зэрэг хугацаа зарцуулснаа санаж байна уу? Тэр үед та Марчийн эгч дүүстэй найзууд болж байсан уу?

Хэцүү хүнд хэллэгтэй, олон бүлгийг унших нь авьяаслаг залуу уншигчдын хувьд ч зохиолын агуулга, дүрүүдийг бүрхэг болгож мэдэх юм. Сонгодог зохиолуудын товчилж, шинэчилсэн хувилбаруудыг унших нь хүнд хэцүү үг хэллэг, хэцүү сэдвүүдээс шантрахгүйгээр үйл явдал болон дүрүүдийг ойлгоход нь хүүхдүүдэд тустай.

Сонгодог зохиолуудын товчилсон хувилбаруудыг уншсанаар залуу уншигчид маань “том ном” уншиж дуусгасны баяр хөөр болон бие даасан байдлаа мэдэрдэг. Сонгодог зохиолд шимтэн дурласнаараа хүүхэд зохиолын сэдэв, үйл явдал, дүрүүдийн талаар улам ихийг ойлгож мэддэг. Уншигчийн чадвар дээшилж, товчлоогүй эх зохиолыг нь унших хүсэл өөрийн эрхгүй аяндаа төрдөг.

Хэрэв залуу уншигчдад хүрч чадсан бол эдгээр зохиол нь тэдэнд нийгэм, гэр бүлийн орчинд өөрийгөө ойлгож мэдэхэд нь үнэлж баршгүй чухал хэрэгсэл болдог. Ийм учраас “Сонгодог зохиолуудын цуврал” нь дүрүүдийн нөлөө болон өнөөгийн нийгэмтэй хамааралтай хэлэлцэх асуултуудыг багтаасан байдаг. Өнгөрсөн үеийн асуудлууд, үнэт зүйлс хэм хэмжээнүүдийг бидний өнөөгийн амьдарч буй нөхцөл байдал дор авч үзээд бид сонгодог зохиолуудад хувиараа болоод бусад байдлаар талархах болдог.

Залуу уншигчдаа сонгодог зохиолуудад дуртай болгож, мөрөөдөл төсөөллийн ертөнцийг бий болгох нь амьдралыг уртасгадаг шүү дээ.

Чи юу гэж бодож байна вэ?

Ярилцлагын асуултууд

“Яагаад?” гэсэн асуулт амнаас нь салдаггүй хөөрхөн жаалын дэргэд байсан уу? Багш нар хичээлээ эхлэхийн өмнө гэрийн даалгавар асуудаг уу? Аав ээж чинь оройн хоолны үеэр чамаас юу ч асуудаггүй юу? Бид өдөр тутам янз бүрийн асуулттай тулгарч байдаг. Гэвч зарим асуултад зөв хариулт өгч чадахгүй байх нь бий.

Дараах асуултууд бол дөнгөж сая чиний уншиж дууссан номын тухай юм. Эдгээр асуулт бол энэ зохиолын баатрууд, үйл явдлуудыг янз бүрийн өнцгөөс харахад тань туслах зорилготой билээ. Асуултуудад заавал нэг л хариулт өгөх албагүй. Эдгээр асуулт аливаа зүйлийг цоо шинээр тунгаан бодоход хүргэж болох юм.

Асуулт бүрийг сайтар бодоод энэхүү сонгомол зохиолын тухай илүү ихийг нээхийг хичээ.

1. Цөлд тааралдсан цагаан арьст хүн анчин Аллан Куатермэйнд юу гэж хэлдэг вэ? Очир эрдэнэ, ус хоёрын аль нь илүү үнэтэй вэ?
2. Цөлийн амьдрал ямаршүү байв? Халуун нар, хуурай агаар, хатаж ундаасах зэргийг өөртөө төсөөлөөд үзээрэй. Та нар ер нь цөлд очиж үзсэн үү?
3. Оддын хөвгүүд гэж хэнийг хэлж байна вэ? Гүүд болон бусад цагаан арьстнууд кукуана хүмүүсийг юугаараа гайхашруулсан бэ?
4. Хааны овоохой руу Умбора харахдаа шүдээ зуун, царайд нь хилэн тодордогийн учир юу вэ? Хамт аялагчид нь үүнийг анзаардаг уу?
5. Төөрсөөр төрөлдөө гэдэг үгийн талаар эргэцүүлэн ярилцаарай. Та нар ийм жишээг амьдрал дээр мэдэх үү?
6. Зөнч эмгэн Гагоол жинхэнэ зөнч байсан гэж та нар мэдэж байна уу? Зөнчдийн тухай та нар юу мэдэх вэ? Амьдралыг хүн өөрөө удирддаг уу, эсвэл хэн нэгэн шидтэн, зөн бэлгэтэн зааж, заавардах ёстой юу?
7. Игноси яагаад бусад хар арьстнуудын нэгэн адил цагаан арьстнуудын ердийн эд хэрэглэл, үйл хөдлөлийг ид шид гэж бодоогүй вэ?
8. Кукуана орны хаадыг хэрхэн яаж оршуулдаг вэ?
9. Гагоол тэдэнд ямаршүү “сюрприз” барьсан бэ? Таглагдсан эрдэнэсийн сангаас амьд мэнд гарахад хэний ямар туршлага, мэдлэг хэрэг болов? Ганцаараа явж байгаад төөрөх ч юм уу, өөр ямар нэгэн хэцүү байдалд та нар орж байсан уу?

Chapter one

Neville, the Man

I am about to narrate a strange tale. When you'll come to hear the end of the tale, you will surely agree that it had some strange, weird, and incredible things that are almost blood-chilling. At least they turn my blood to ice many a times.

I am no professional writer. I am just a hunter called Allan Quatermain. I am a white man residing in Durban, South Africa. In my life of fifty years. I have spent more than thirty years in hunting, fighting, mining and trading in parts of Africa. I am sure I must have killed at least sixty-five lions. My sixty-sixth victim attacked me and his mauling caused me to limp in my left leg.

Nearly eighteen months ago I met Captain Good and Sir Henry Curtis for the very first time. That's when my story starts. In that year (1885) I was just of Bamangwato busy hunting elephants. Bad luck, all the wrong decisions and a high fever to top it all made this trip a miserable one.

After I got well I collected all the worry I had got and took it to the Cape. I spent a week in Cape Town and thought of taking the Dunkeld back to Durban. The ship was then waiting for the Edinburgh Castle to arrive from England. I went up to my berth in the Dunkeld. Shortly the other ship arrived, its passengers went aboard the Dunkeld and we set sail.

Among the passengers who came on board there were two who caught my interest. One, a man of about thirty, was one of the biggest and strongest-looking men I ever saw. He had yellow hair and beard, clear-cut features and large grey eyes set deep in his head. I found out, by looking at the passenger list, that this was Sir Henry Curtis. He reminded me very much of somebody else, but at the time I could not remember who it was.

The man with him was listed as Captain John Good, and I put him down at once as a naval officer. He was stout and dark, and very neat and very clean-shaved, and he always wore an eye-glass in his right eye.

That evening I went into the ship's lounge for drink and a chat, and found Sir Henry and his friend already there. Some-how we got into talk about shooting elephants and a man who knew me, and who was sitting nearby, called out; "Hunter Quatermain should be able to tell you about elephants if anybody can.

Sir Henry gave a start and stared at me: "Excuse me, sir," he said, "but is your name Allan Quatermain."

I said it was. Sir Henry and Captain Good looked at each other, then Curtis turned back to me.

"We have come from England to find you," he said. "I wish to talk with you, privately. Will you come to my cabin so that we can speak without being overheard?"

I was puzzled, but said I would. The cabin was a very good one. Sir Henry poured drinks and then

said: “Mr. Quatermain, the year before last about this time you were, I believe, at a place called Bamangwato, to the north of the Transvaal?”

“Yes,” I answered, surprised that he should know it.

“Did you happen to meet a man called Neville there?”

“Neville? Why, yes—he camped alongside of me for a week or two. I had a letter from a lawyer a few months back asking if I knew what had become of him.”

“I know,” Curtis said. “Your reply was sent on to me. It was not very clear, Mr. Quatermain. Tell me, do you know where Mr.—er—Mr. Neville was going?”

“I did hear something,” I said, and stopped there.

Then came a pause. Curtis and Good looked at each other, and finally Good nodded his head. Sir Henry turned back to me.

“I’m going to tell you the truth,” he said. “The man you knew as Neville was my brother.”

I sat up and slapped my leg. “Of course! I see it now there’s a real likeness.”

“Yes,” Curtis said. “Five years ago, just before my father died, I quarrelled with my brother George. My father had put off making his will until it was too late and, as the eldest son, I inherited all his property. My brother was naturally bitter about this. I intended to make up the quarrel with him and share the inheritance, but before I could do so he took the name of Neville and set off for Africa, in the hope of making a fortune, I suppose. That was three years ago and I’ve heard nothing from him since. I’m deeply troubled about him and I’ve come out here to find him.”

“Perhaps, sir,” said the captain, “you’ll tell us what you know about Mr. Neville?”

Sir Henry leaned forward and stared straight into my eyes.

“What was it you heard at Bamangwato, about my brother’s journey?”

“I heard that he was looking for Solomon’s Mines.”

I gazed from one to the other. Both were staring at me.

“Solomon’s Mines!” they exclaimed together. “Where are they?”

“I know where they are said to be,” I answered. “Beyond some mountains that I once saw ... the Suliman Berg or Solomon’s Mountains, they’re called—but there were a hundred and thirty miles of desert between me and them. There’s a legend in Africa that it was somewhere up to the north of the Suliman Berg that King Solomon had his diamond mines.”

Curtis was frowning at me, eyebrows tight drawn.

“Good Lord!” he said. “King Solomon of the Bible? It can’t be true!”

“Why not?” I asked. “I’ve been a long time in Africa, gentlemen, and I’ve seen some odd things and heard some odd tales. But none more curious than the one I’m going to tell you now.” ‘I got to my feet and began to pace the cabin floor, wondering how I should tell it, while they watched me and waited for my tale. And as I paced, the memories came flooding back and I saw again my mind’s eye the face of a dying man and heard him gasp out his last beside my camp fire all those years ago...